БОЛОВСРОЛЫН СУДАЛГААНЫ ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2026 оны 10 сарын 05 өдөр Дугаар А/76 Улаанбаатар хот

Нэгдүгээр ангийн бүтээлч үйл ажиллагааг хэрэгжүүлэх зөвлөмж, жишиг төлөвлөлт батлах тухай

Боловсролын ерөнхий хуулийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсэг, Боловсролын сайдын 2026 оны "Сургалтын хөтөлбөр шинэчлэн батлах тухай" А/46 дугаар тушаал, "Хөтөлбөр арга хэмжээний 2026 оны жагсаалт шинэчлэн батлах тухай" А/260 дугаар тушаал, "Зардал батлах тухай" А/262 тушаал, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн дүрмийн 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Нэгдүгээр ангийн бүтээлч үйл ажиллагааг хэрэгжүүлэх зөвлөмж, жишиг төлөвлөлтийг хавсралтаар баталсугай.

2.Нэгдүгээр ангийн бүтээлч үйл ажиллагааг хэрэгжүүлэх зөвлөмж, жишиг төлөвлөлтийг Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн цахим хуудаст байршуулж, Боловсролын ерөнхий газарт хүргүүлэн үр дүнг тайлагнахыг Сургалтын хөтөлбөр, сурах бичгийн судалгааны сектор (Б.Алтансүх)-т үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын мэргэжилтэн (О.Манзушир)-д даалгасугай.

ЗАХИРЛЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ Х.ОТГОНБААТАР

14262000286

Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн
захирлын 2026 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн
А/176 дугаар тушаалын хавсралт

НЭГДҮГЭЭР АНГИЙН БҮТЭЭЛЧ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗӨВЛӨМЖ, ЖИШИГ ТӨЛӨВЛӨЛТ

(Ерөнхий боловсролын сургуулийн нэгдүгээр ангийн багшид зориулав)

Улаанбаатар хот
2026 он

АГУУЛГА

УДИРТГАЛ 3

НЭГ. БАГА БОЛОВСРОЛЫН СУРАЛЦАГЧИЙН БҮТЭЭЛЧ ҮЙЛ АЖИЛЛАГАА 4

1.1. Бүтээлч үйл ажиллагаа гэж юу вэ? 4

1.2. Сургалтын хөтөлбөр ба бүтээлч үйл ажиллагааны уялдаа 4

ХОЁР. НЭГДҮГЭЭР АНГИД ХЭРЭГЖҮҮЛЭХ "БҮТЭЭЛЧ ҮЙЛ АЖИЛЛАГАА"-НЫ ЦАГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЖИШИГ ҮЙЛ АЖИЛЛАГАА 7

2.1. 6 настай суралцагчийн бие бялдар, танин мэдэхүй, нийгэмшлийн хөгжлийн онцлог 7

2.2. Чиглэл 1. Судлах, турших, асуудал шийдвэрлэх, зохион бүтээх 8

2.3. Чиглэл 2. Хэл, урлаг, хөгжим, хөдөлгөөнөөр бүтээлчээр илэрхийлэх 10

2.4. Чиглэл 3. Хамтран бүтээх, оролцох орчноо дэмжих 12

2.5. Чиглэл 4. Өөрийгөө болон бусдын ажил хөдөлмөр, өв соёл, орон нутгаа танин мэдэх 14

2.6. Бүтээлч үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга зүй 16

2.7. Явцын үнэлгээ, баримтжуулалт 20

2.8. Хэрэгжилт, зохион байгуулалт 22

ХАВСРАЛТ. НЭГДҮГЭЭР АНГИЙН "БҮТЭЭЛЧ ҮЙЛ АЖИЛЛАГАА"-НЫ ТӨЛӨВЛӨЛТ, ЖИШИГ ҮЙЛ АЖИЛЛАГАА 23

Сэдэв 1. Машины хөдөлгөөнт загвар хийж турших 26

Сэдэв 2. Хөгжимт хөдөлгөөн 28

Сэдэв 3. Хамтдаа бүтээсэн зураг 31

Сэдэв 4. Бид нэг ангийнхан 33

Сэдэв 5. Музейн аялал 35

Сэдэв 6. Бидний дэг 38

Сэдэв 7. Миний бяцхан найз 40

Сэдэв 8. Өвлийн орчин 41

Сэдэв 9. Нөхөрсөг харилцаа 43

Сэдэв 10. Манай сургуулийн орчны амьд байгалийн зураглал 45

Сэдэв 11. Чарга угсрах 47

Сэдэв 12. Монгол гэр угсрах 50

ЭХ СУРВАЛЖ 54

УДИРТГАЛ

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 176 дугаар тогтоолоор “Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал”-ыг баталсан. Тус үзэл баримтлалд “...хувь хүний ялгаатай хэрэгцээ, суралцахуйн хэв маягт тохирсон уян хатан, олон хувилбарт сургалтын хөтөлбөрийн шинэчлэл чухал болж байна” хэмээн онцолж, суралцагчдын эзэмших суурь болон ерөнхий чадамжийг тодорхойлсон билээ.

Дээрх үзэл баримтлалд нийцүүлэн сургуулийн түвшинд суралцагчийн сурах үйл ажиллагааг дэмжсэн удирдлага, манлайллыг хэрэгжүүлэх, багшид суралцагчийн чадамжийг хөгжүүлэх өдөр тутмын танхимын ба танхимын бус сургалт, бие даан суралцах үйл ажиллагааг төлөвлөн чиглүүлэх, суралцагчид зорилготойгоор сурах, эцэг эх, асран хамгаалагчдад хүүхдийнхээ сурах үйлд дэмжлэг үзүүлэх үндсэн баримт бичиг болгож бага боловсролын сургалтын хөтөлбөрийг боловсруулсан. Энэхүү баримт бичигт “Бага боловсролын сургалтын хөтөлбөрийг танхимын сургалтаар хэрэгжүүлэхийн зэрэгцээ агуулга, суралцахуйн үр дүнгийн тодорхой хэсгийг танхимын бус сургалт, үйл ажиллагаагаар хэрэгжүүлнэ” гэж тусгажээ. Суралцагчийн бүтээлчээр сэтгэх, асуудал шийдвэрлэх, хамтран ажиллах, сурч мэдсэнээ ашиглан асуудал шийдвэрлэх чадамжуудыг хөгжүүлэхэд чиглэсэн төсөлт ажлуудыг төлөвлөж хэрэгжүүлэх, хэлэлцэх, ялгаатай санал гаргах зэргийг тогтмол дэмжиж, чиглүүлж ажиллана. Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ агуулгыг орон нутгийн түүх соёл, түүхэн болон байгалийн дурсгалт газар, хэлний онцлогийг харгалзан, суралцахуйн үр дүнтэй нийцүүлэн баяжуулж болно" хэмээсэн байна.

Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг дэмжиж, суралцагчийг хөгжүүлэх танхимын болон танхимын бус үйл ажиллагааг хэрэгжүүлэх шаардлагыг үндэслэн сургалтын төлөвлөгөөнд “Бүтээлч үйл ажиллагаа”-ны цагийг тусгайлан тусгаж, Боловсролын сайдын 2026 оны А/277 дугаар тушаалаар нэгдүгээр ангийн суралцагчдын бүтээлч үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд баримтлах чиглэлийг баталсан.

Иймд тухайн сургууль орон нутгийн онцлогийг харгалзсан, суралцагчдын хэрэгцээ, сонирхолд нийцсэн, судлагдахуунаар эзэмшсэн мэдлэг, чадвараа өдөр тутмын амьдралд бүтээлчээр хэрэглэх боломжийг бүрдүүлсэн бүтээлч үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэх шаардлагатай байна. Бага ангийн сургалтын хөтөлбөрийн зорилго, суралцахуйн үр дүнгийн хэрэгжилтийг дэмжих “Бүтээлч үйл ажиллагаа”-ны цагийг сургалтын төлөвлөгөөтэй уялдуулан төлөвлөх, зохион байгуулахад багшид арга зүйн дэмжлэг үзүүлэх зорилгоор энэхүү зөвлөмжийг боловсруулав.

НЭГ. БАГА БОЛОВСРОЛЫН СУРАЛЦАГЧИЙН БҮТЭЭЛЧ ҮЙЛ АЖИЛЛАГАА

1.1. Бүтээлч үйл ажиллагаа гэж юу вэ?

"Бүтээлч үйл ажиллагаа" нь суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадварыг бодит нөхцөлд хэрэглэх, судлах, турших, бүтээх, асуудал шийдвэрлэх хамтран ажиллах үйл ажиллагаагаар дамжуулан суурь болон ерөнхий чадамжийг хөгжүүлэхэд чиглэнэ.

Бага боловсролын түвшинд бүтээлч үйл ажиллагааг хөгжүүлнэ гэдэг нь дэвшүүлсэн нэг асуудалд олон өөр, өвөрмөц шийдэл хайх чадварыг өдөөх үйл явц юм[1]. (Ж.П.Гилфорд, 1950). Энэ нь "боломжийг эрэлхийлэх сэтгэлгээ" буюу аливааг байгаагаар нь шууд хүлээж авахаас татгалзаж, "Хэрэв ингэвэл яах вэ?" гэсэн асуултын хариулт, өдөр тутмын "жижиг бүтээлч байдал"-аар илэрдэг (Анна Крафт, 2005) гэж тодорхойлжээ[2].

Бүтээлч үйл ажиллагаа нь суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадварыг хэрэглэх, бататгах, баяжуулах, өөрийгөө танин мэдэх, нээн илрүүлэх, хөгжих боломжийг нээсэн идэвхтэй үйл ажиллагаа байна. Хамт олноороо хийх үйл ажиллагаагаар дамжуулан хүн хоорондын зүй зохистой, хүнлэг харилцааг бий болгох, хамт олныхоо, нэгэн гишүүний хувьд өөрийнхөө талаар эргэцүүлэн бодох, өөрийгөө хөгжүүлэх чадварт суралцах явдал юм. Мөн суралцагч бодит үйл ажиллагаанд оролцох явцдаа эрэл хайгуул хийх, асуудал олж харах, эргэцүүлэн бодох, дүгнэх асуудлыг илүү сайнаар шийдвэр гаргах чадварт суралцана. Өөрөөр хэлбэл суралцагч өөрийнхөө хувьд шинэ санаа, арга, бүтээлийг бий болгох үйл явц юм.

Иймээс багш бүтээлч үйл ажиллагааны явцад асуудлыг олон талаас нь харах боломжийг олгож, суралцагчид бэлэн загварыг шууд даган дуурайхаас татгалзан, шинэ санаа сонирхолтой үр дүн гарах орон зайг үлдээх нь чухал юм. (OECD, 2019).

"Бүтээлч үйл ажиллагаа"-ны цагаар суралцагчийн хичээл дээр судалсан суралцахуйн үр дүнгийн хүрээнд эзэмшсэн мэдлэг, ойлголт, чадвараа бататгах зорилго бүхий бодит амьдралд хэрэглэх, харилцах, хамтран ажиллах, өөрийгөө илэрхийлэх боломжийг олгосон танхимын болон танхимын бус үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

1.2. Сургалтын хөтөлбөр ба бүтээлч үйл ажиллагааны уялдаа

Бага боловсролын сургалтын хөтөлбөрт дараах ерөнхий болон суурь чадамжуудыг хөгжүүлэхээр тусгасан байна. Бага боловсролын судлагдахуун бүрийн сургалтын хөтөлбөр нь суралцагчийн суурь болон ерөнхий чадамжийг хөгжүүлэх зорилготой.

---

[1] Guilford, J. P. (1950). Creativity. American Psychologist, 5(9), 444–454.

[2] Craft, A. (2005). Creativity in Schools: Tensions and Dilemmas. Routledge.



Зураг 1. Сургалтын хөтөлбөр ба бүтээлч үйл ажиллагааны уялдаа

Суралцагч бүрийн сурах арга барил, зорилго хэрэгцээ ялгаатай байдгийг харгалзан эзэмшсэн мэдлэг, чадварыг хэрэглэх, бататгах, баяжуулах, өөрийгөө танин мэдэх, нээн илрүүлэхэд чиглэсэн танхим болон танхимын бус бүтээлч үйл ажиллагааг зохион байгуулахдаа тухайн улиралд судалсан судлагдахуунуудын агуулгын интеграцийг харгалзана. *(Хүснэгт 1)*

Хүснэгт 1. Сургалтын хөтөлбөр ба бүтээлч үйл ажиллагааны уялдааны жишээ

Судлагдахууны хөтөлбөрийн суралцахуйн үр дүн	Агуулгын чиглэл	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа
Нийгмийн ухаан (НУ-1.1б): Эцэг эх, багш, найз нөхөдтэйгөө харилцахдаа хүндэтгэлийн үг хэрэглэх. Байгаль шинжлэл (БШ-1.1а, 1.4в): Амьд ба амьгүй биетийг ажиглах, дөрвөн улирлаас хамаарч байгаль орчинд гарч байгаа өөрчлөлтийг ялгах. Дүрслэх урлаг, дизайн (ДУД-1.2к): Байгалийн материал (навч)-ын хэлбэр, дүрсийг ажиглан сонгож өрөх, наах аргаар бүтээл хийж анхны санаагаа өөрчлөн сайжруулах.	Чиглэл 2. Хэл, урлаг, хөгжим, хөдөлгөөнөөр бүтээлчээр илэрхийлэх Дэд сэдэв: “Дахин ашиглах материалаар хамтын бүтээл урлах.”	Суралцагчид өөрийн болон найз нөхдийнхөө ижил ба ялгаатай талыг танин мэдэж, анги хамт олондоо хүүхэд бүр хувь нэмэртэй болохыг ойлгох; бусдыг анхааралтай сонсох, багаар хамтран ажиллах замаар байгалийн унасан навч ба гарын хээгээр "Нэг ангийнхан мод" бүтээх.

Дээрх хүснэгтэд харуулсан бүтээлч үйл ажиллагааг Байгаль шинжлэлийн байгалийг ажиглах (намрын улиралд модны навч унах, өнгө хэлбэрийн олон янз байдал), нийгмийн

ухааны нийгэмшихүй буюу сурагч "Би" гэх үзлээс "Бид" гэсэн анги хамт олны гишүүн болох агуулгатай уялдуулсан. Модны олон өнгийн (намар) навч нийлж нэг мод, бид өөр хоорондоо ялгаатай ч бид нэг анги гэсэн утгыг дүрслэх урлаг, дизайны байгалийн ба дүрслэх материал (гарын хээ, унасан навч) ашиглан 2 хэмжээст наамал бүтээлээр илэрхийлнэ. Энэхүү үйл ажиллагаа нь суралцагчийн шинжлэх ухаан (байгаль ба нийгмийн ухаан), урлаг, гоо зүй (дүрслэх урлаг, дизайн) болон эх хэл, харилцааны суурь чадамжийг хөгжүүлэхийн зэрэгцээ тэдний нийгэм-сэтгэл хөдлөл, хамтран ажиллах, бүтээлчээр сэтгэх болон шүүн тунгаах ерөнхий чадамжийг нэгдмэл байдлаар хөгжүүлэхэд бодит хувь нэмэр оруулна.

Боловсролын сайдын чиглэл батлах тухай А/277 дугаар тушаалаар батлагдсан бүтээлч үйл ажиллагааны агуулгын 4 чиглэл бүрийн хэрэгжүүлэх агуулгын хүрээг баримтлан судлагдахууны интеграци агуулгатай уялдуулан зохион байгуулна. Нэгдүгээр ангид тоглоом болон шинэ санаа гаргах, сонголт хийх, турших, бүтээх, хамтрах, хийснээ эргэцүүлэх, сайжруулах зэрэг үйлээр дамжуулан суралцагчийг хөгжүүлэхэд анхаарна. *(Хүснэгт 2)*

Агуулгын чиглэл	Хэрэгжүүлэх агуулгын хүрээ
Ч 1.Судлах, турших, асуудал шийдвэрлэх, зохион бүтээх	- Сургууль ба орчны тулгамдсан асуудлыг илрүүлэн шийдвэрлэх бичил төсөлт ажил хийх; - Өрхийн болон өөрийн санхүүгийн хэрэглээг зөв зарцуулах; - Дахин ашиглах материалаар болон STEAM хэрэглэгдэхүүнээр зохион бүтээж, турших; - Сургуулийн орчинд ажиглалт хийж амьд биесийг бүртгэх, тоолж харьцуулах.
Ч 2.Хэл, урлаг, хөгжим, хөдөлгөөнөөр бүтээлчээр илэрхийлэх	- Бүтээлчээр унших, өөрийн санаа бодлыг илэрхийлэх; - Дахин ашиглах материалаар хамтын бүтээл урлах; - Зураг зурах, баримал бүтээх; - Хөгжмийн хэмнэлд тохируулан хөдөлгөөн ба дүрийн тоглолт хийх.
Ч 3. Хамтран бүтээх,оролцох, орчноо дэмжих	- Өдөр тутмын дасгал хөдөлгөөн, гимнастик хийх; - Багийн ажлын үүргийг хуваарилах, бусадтай эелдэг харилцах идэвхтэй оролцох; - Тусламж хэрэгтэй нэгэндээ туслах, бусдын ялгаатай байдлыг хүндэтгэх; - Эрүүл мэндээ хамгаалах, ариун цэврийг сахих, аюулгүй байдлаа хангах,цахим хэрэгслийг зөв зохистой хэрэглэх.
Ч 4.Өөрийгөө болон ажил хөдөлмөр, өв соёл, орон нутгаа танин мэдэх	- Өөрийн сонирхол, сэтгэл хөдлөлөө илэрхийлэх, "Би хэн бэ?" танилцуулга хийх; - Орон нутгийн байгалийн үзэсгэлэнт газар, дурсгалт газар, түүхийн музейтэй танилцах; - Монгол өв уламжлал, ахуйн соёлтой танилцах; - Орон нутгийн хүмүүсийн ажил хөдөлмөрийн онцлогтой танилцах.

Нэгдүгээр ангийн дээрх агуулгыг тухайн улиралд судалж байгаа судлагдахууны суралцахуйн үр дүнтэй уялдуулахад анхаарна.

ХОЁР. НЭГДҮГЭЭР АНГИД ХЭРЭГЖҮҮЛЭХ “БҮТЭЭЛЧ ҮЙЛ АЖИЛЛАГАА”-НЫ ЦАГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЖИШИГ ҮЙЛ АЖИЛЛАГАА

2.1. 6 настай суралцагчийн бие бялдар, танин мэдэхүй, нийгэмшлийн хөгжлийн онцлог

Танин мэдэхүйн хөгжлийн онцлог

- Бодит үгийн нөөц давамгайлдаг бөгөөд харагдаж байгаа зүйлийг байгаагаар нь тоочин энгийн богино өгүүлбэрээр ярих нь давамгай байдаг.
- 2 минутад зорилго чиглэлтэйгээр санаа бодлоо илэрхийлэхдээ дунджаар 34-35 үгийг хэрэглэдэг.
- Энгийн богино өгүүллэг, үлгэр, зураг номыг утгаар нь хялбар тогтоодог боловч анхаарлаа төвлөрүүлэн хурдтай ажиллахад бэрхшээлтэй байдаг.
- Үзэгдэл юмсыг хурдан хугацаанд ерөнхий дүр байдлаар хүртдэг харин бүтэц, бүрэлдэхүүнийг ажиглан хүртэхдээ нэлээд удаан хугацаа шаарддаг[3].
- Юмсыг өнгө, хэлбэр, дүрс, материалаар нь ангилах болон гол ба гол биш шинжийг ялгадаг.
- Суралцагчдад юмс үзэгдлийг бодитоор харж, биеэр хийж, мэдрэхүйн 5 эрхтнээр хүртэн үйлдэж танин мэддэг бодит сэтгэхүй давамгайлдаг[4].
- Өмнөх туршлага дээрээ тулгуурлан шинэ зүйл сурахдаа идэвхтэй бөгөөд дахин давтан хийж байж сурдаг онцлогтой.
- Ялгаж тайлбарлах чадвартай.
- Эргэцүүлэн бодож, байгаль ба юмсын тухай учир шалтгааныг танин мэдэхийг хүсэж байнга “яагаад” гэж асуудаг бөгөөд зохион бодох чадвар нь хязгаарлагдмал шинжтэй байдаг.

Бие бялдрын хөгжлийн онцлог

- Том булчин нь жижиг булчингаас илүү хөгжсөн тул зурах, хайчлах, наах гэх мэт жижиг булчингийн нарийн үйлд эв дүйгүй, амархан ядардаг.
- Үзэг, харандаа, зургийн хэрэгслийг бүр урд хэсгээр нь чанга атгаж барьдаг бөгөөд ихэнхдээ маш их даралт өгч зурж бичдэг.
- Суралцагчид тогтворгүй, хөдөлгөөнтэй, хэт идэвхтэй,амархан ядардаг.
- Гар ба нүдний баримжаа сайжирч ирдэг бөгөөд сонирхсон зүйлээ дахин давтан шаргуу хийж гүйцэтгэдэг.
- Аливаа бүтээлч үйлийг сайн эхэлдэг боловч эцэст нь хүртэл гүйцэд хийхэд багшийн чиглүүлэг, тусламж хэрэгтэй байдаг.

Нийгэмшлийн хөгжлийн онцлог

- Ажилдаа хариуцлагатай хандах, зан төлөвөө зохицуулах, үйл ажиллагаанд идэвхтэй оролцох чадвар сайн, сэтгэл санааны хувьд өөдрөг байдаг.
- Үеийнхэнтэйгээ нийгэмшиж, багаар хамтарч сурч, тоглож, хэрэглэгдэхүүнээ хуваалцаж эхэлдэг.
- Насанд хүрэгчдийн тайлбар, учирлаж хэлсэн үгийг дуулгавартай сонсож, том хүмүүсийг дуурайхыг хичээдэг.

---

[3] (Бэгз, Н., Санжаабадам, С., бусад.(2023). “Монгол хүүхдийн бие бялдар, нийгэмшил, танин мэдэхүйн хөгжлийн онцлог”. БСҮХ. УБ.х.89-90.

[4] Цогзолмаа, Д., Монголхатан, Г., бусад. “Нэгдүгээр ангийн бэлтгэл хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүй сургалтын модуль”.БСШУЯ. УБ.х. 5-6.

- Анги ба сургуулийн орчинд тогтоосон энгийн дүрэм, дэгийг биелүүлэхийг эрмэлздэг.
- Бурууг нь шууд хэлэхэд ихэнхдээ булталж, найз нөхөд болон бусдыг буруутгах хандлагатай байдаг.
- Зэмлэл, шүүмжлэлийг хүлээн авахдаа дургүй, харин хийсэн бүтээлийг нь хүлээн зөвшөөрч урам зориг өгвөл маш их дуртай байдаг.
- Хатуу чанд шалгуур, дарамтгүй орчинд бие даан болон багаар үүрэг хариуцлага хүлээх чадвартай байдаг.

Багшид зориулсан зөвлөмж

Нэгдүгээр ангийн суралцагчийн дээрх нийтлэг онцлогийг харгалзан, санал болгож буй агуулгын хүрээнд дараах зөвлөмжийг баримтлан танхим болон танхимын бус бүтээлч үйл ажиллагааг зохион байгуулна. Үүнд:

- Бүтээлч үйл ажиллагаанд бодит үзүүлэн, туршилт, дадлагад тулгуурлан мэдрэхүйн 5 эрхтнээр нь дамжуулан суралцах, хүртэх боломжийг бүрдүүлэх;
- Бүтээлийн загвар, бүтцийг нарийвчлан ажиглах хангалттай хугацааг суралцагчдад олгох;
- Богино хугацаанд харж тогтоох онцлогийг харгалзан даалгаврын ачаалал, санамж зааварчилгааг 3–4 алхмаас хэтрүүлэхгүй тохируулах;
- Суралцагчдын тоочих яриаг дэмжихийн зэрэгцээ тэмдэг нэр, сэтгэлийн үгсийг бүтээлдээ ашиглаж, санаагаа бүтэн өгүүлбэрээр илэрхийлэхэд чиглүүлэх;
- Гарын жижиг булчингийн ачааллыг тохируулж, харандаа болон баримлын шавартай ажиллах явцад гараа амраах дасгал хийлгэх;
- Охид, хөвгүүдийн уян хатан байдал болон тэсрэлтэт хүчний онцлогт тохирсон хөдөлгөөнт болон жүжигчилсэн тоглоомыг судлагдахууны агуулгатай уялдуулах;
- Бүтээж эхэлсэн ажлыг нь эцэст нь хүртэл хийж дуусгахад нь багш болон үеийнхэн нь дэмжлэг үзүүлж, урамшуулах;
- Бүтээлч үйл ажиллагааны орчинд сахих дэг, аюулгүй байдлын санамжийг зургаар ойлгомжтой үзүүлэн болгож хэвшүүлэх;
- Шүүмжилж зэмлэхээс зайлсхийж, суралцагчийн санаа болон хийсэн бүтээл бүрийг нь сайн магтаж урамшуулах;
- Алдаагаа засах, зохистой зан үйлд суралцахад нь дэмжлэг үзүүлэхдээ бусдын өмнө зэмлэхгүй, ганцаарчлан элдгээр ярилцаж, учирлан тайлбарлах;
- Багаар хамтран бүтээл урлах, бие биеэ сонсох, хэрэглэгдэхүүнээ хуваалцах соёлд сургаж чиглүүлэх.

2.2. Чиглэл 1. Судлах, турших, асуудал шийдвэрлэх, зохион бүтээх

Зорилго: Суралцагч өөрийн эргэн тойрноо ажиглаж, тулгарч буй асуудлыг илрүүлэх, шинэ санаа дэвшүүлэх, туршилтаар санаагаа сайжруулах, шийдлээ тайлбарлах чадварт суралцана.

Үндсэн ойлголт:

Сургууль ба орчны тулгамдсан асуудлыг илрүүлэн шийдвэрлэх бичил төсөлт ажил хийх. Суралцагчид өөрсдийн амьдарч, суралцаж буй орчин (гэр, сургууль) дахь жижиг асуудлыг ажиглан илрүүлж, асуудлаа шийдвэрлэх санааг хосоор, багаараа дэвшүүлж, санаа шийдлээ туршин дахин сайжруулж, сайжруулсан хувилбараа бусдад танилцуулахад чиглэнэ.

Танхимын үйл ажиллагаа:

- Ангид тулгамдсан асуудлуудыг илрүүлэх (ангид байгаа хэрэглэгдэхүүн, эд зүйлсийн эмх цэгцгүй байдал, завсарлагаанаар ангиас гарахад бие биеэ шахаж түлхдэг г.м)
- Гэрлэн дохионы дүрмээр ангийн дуу чимээг багасгах.

Танхимын бус үйл ажиллагаа:

- Сургуулийн коридор, гадна талбайн аюултай хэсгүүдийг ажиглан, аюултай байдлыг анхааруулах тэмдэглэгээ байршуулах;
- Чиглэл заасан хуудас ашиглан шалан дээрх саадыг тойрч, зорьсон газарт хүрэх хөдөлгөөний дарааллыг зохиох;

- Гэртээ хог хаягдлыг (цаас, хуванцар) ангилах булан үүсгэж, гэр бүлийнхэнтэйгээ туршин, анхны гаргасан санааг сайжруулах, ангийнхандаа танилцуулах.

Өрхийн болон өөрийн санхүүгийн хэрэглээг зөв зарцуулах. Суралцагч өдөр тутмын хэрэгцээт зүйлсээ (хүнс, ус, цахилгаан, хичээлийн хэрэгсэл) арвилан хэмнэх, "Дэлгүүр" тоглоом ба хуримтлалын хайрцгаар дамжуулан хуримтлалын ач холбогдлыг ойлгож, зөв зарцуулах хэрэглээний дадалд суралцана.

Танхимын үйл ажиллагаа:

- Мөнгөний хуримтлалын хайрцаг хийх (цаасан аяга ба хайрцаг ашиглан хуримтлалын хайрцаг хийж, чимэглэх);
- "Дэлгүүр" тоглоомд оролцох (Мөнгөөр хэрэгцээт хичээлийн хэрэгслээ төлөвлөн худалдан авах дүрд тоглох).

Танхимын бус үйл ажиллагаа:

- Эцэг эхтэйгээ дэлгүүр орж худалдан авалт хийж, баримт болон бараг тулгаж, тоолох
- Гэртээ хуримтлалын хайрцагтаа задгай мөнгө хийж, арвилан хэмнэх арга ухаанд суралцах.

Дахин ашиглах материал болон STEAM хэрэглэгдэхүүнээр зохион бүтээж, турших. Эрүүл ахуйн шаардлага хангасан дахин ашиглах материал (цаасан хайрцаг, соруул, хуванцар таглаа, резин, модон саваа) ашиглан хөдөлгөөнт, 3 хэмжээст техникийн загвар (машин, чарга, усанд хөвөгч онгоц, савлуур, гүүр гэх мэт) угсрах. Зохион бүтээсэн загвар нь анхны туршилтаар нурах, дугуй нь эргэхгүй байх үед алдааг өөрөө илрүүлж, дугуйн тэнхлэг ба бэхэлгээг засан сайжруулах (алдаанаасаа суралцан дахин оролдох) зохион бүтээх сэтгэлгээг хөгжүүлнэ.

Танхимын үйл ажиллагаа:

- Устай сав ба соронз ашиглан материалын усанд хөвөх/живэх, соронзод татагдах шинжийг турших;
- Дахин ашиглах боломжтой цаасан хайрцаг, соруул, таглаагаар машин, чарга, савлуурын 3 хэмжээст загвар зохион бүтээх.

Танхимын бус үйл ажиллагаа:

- Сургуулийн тоглоомын талбайн савлуур, гулсуур дээр түлхэх ба татах хүчний харилцан үйлчлэлийг биеэр турших;

- Зохион бүтээсэн машинаа сургуулийн гаднах налуу замд хөдөлгөж сорих, STEAM үзэсгэлэн гаргах;
- Гэртээ эрүүл ахуйн шаардлага хангасан дахин ашиглах материалаар янз бүрийн гурван хэмжээст загвар бүтээж, дахин сайжруулах.

Сургуулийн орчинд ажиглалт хийж амьд биесийг бүртгэх, тоолж харьцуулах. Суралцагч сургуулийн орчны ургамал, жижиг амьтдыг ажиглан, зурагт тэмдгээр бүртгэж, тоолж харьцуулна. Ажигласан амьд биетээ энгийн газрын зурагт тэмдэглэн, найзууддаа тайлбарлаж, тэдний саналаар зургаа сайжруулж сурна. Ургамал, амьтныг гэмтээлгүй ажиглаж, орчноо хайрлан хамгаалах дадалд суралцана.

Танхимын үйл ажиллагаа:

- Сургуулийн байр, хаалга, явган замыг харуулсан энгийн зураг ажиглаж, танил газруудаа зааж нэрлэх;
- Гадаа ажигласан ургамал, амьтны тэмдэглэгээг нэгтгэж, аль хэсэгт юу олон, цөөн байсныг харьцуулах;
- Сургууль орчмын тойм зураг дээр мод, цэцэг, шувуу зэрэг ажигласан зүйлээ зурагт тэмдгээр нэмж, амьд байгалийн зураглал бүтээх;
- Газрын зургаа (амьд байгалийн зураглал) өөр багт үзүүлж, заасан газрыг олж чадаж байгаа эсэхийг шалган, ойлгомжгүй тэмдэг, дүрслэлийг сайжруулах.

Танхимын бус үйл ажиллагаа:

- Багштайгаа сургуулийн хашаанд урьдчилан сонгосон газруудад ажиглалт хийж, мод, цэцэгтэй ургамал, харагдсан жижиг амьтдыг зурагт ажлын хуудсанд зураас, тэмдгээр бүртгэх;
- Бүтээсэн газрын зургаа ашиглан багшийн хамт тухайн газрыг олж очоод, зурагт тэмдэглэсэн зүйлтэйгээ тулган ажиглах;
- Байгаль орчноо хайрлан хамгаалах сайн дурын аян, үйл ажиллагаанд оролцох.

2.3. Чиглэл 2. Хэл, урлаг, хөгжим, хөдөлгөөнөөр бүтээлчээр илэрхийлэх

Зорилго: Суралцагч өөрийн мэдрэмж, бодол санаагаа хэл, дүрслэх урлаг, хөгжим, хөдөлгөөнт тоглоом ба дүрээр бүтээлчээр илэрхийлэх чадварт суралцана.

Үндсэн ойлголт

Бүтээлчээр унших, өөрийн санаа бодлыг илэрхийлэх. Суралцагч богино хэмжээний эх (зурагт ном, үлгэр, богино эх)-ийг сонсох, уншиж ойлгох, дүрийн сайн ба муу үйлийг ялгах, утга санааг эргэцүүлэх, асуултын дагуу өгүүлбэрээр зохион ярьж, өөрийн сэтгэгдлийг илэрхийлж сурна.

Танхимын үйл ажиллагаа:

- Зурагт ном, үйл явдалтай эхийн дүрүүдийн талаар ярих;
- Цаасан хүүхэлдэй ашиглан бяцхан үлгэрийн дүрд хувирч тоглох;
- Зурагт карт (цэцэг тарьж буй зураг, нохойтойгоо тоглож буй зураг, ойд аялж буй зураг)-ыг ажиглаж, асуултын дагуу 2-3 өгүүлбэрээр зохион ярих.

Танхимын бус үйл ажиллагаа:

- Суралцагч асран хамгаалагчийн (аав, ээж, өвөө, эмээ) хамт сургуулийн болон орон нутгийн номын сангаар зочилж, номын сангийн дүрэмтэй танилцах, өөрийн дуртай зурагт номыг сонгон хамтдаа уншиж, ойлгосон зүйлээ зургаар илэрхийлэх;
- Гэр бүлийн уншлагын цаг зохион байгуулж, уншсан сэдвийнхээ хүрээнд ярилцах.

Зураг зурах, баримал бүтээх. Суралцагч төсөөлөл, мэдрэмжээрээ зурах, гарын доорх болон байгалийн материал ашиглан бүтээл хийх, хийсэн бүтээлээ бусдад танилцуулах.

Танхимын үйл ажиллагаа:

- Зургийн хэрэглэгдэхүүн сонгон үлгэрийн ба төсөөллийн дүрийг зохиомжлон зурах;
- Гарын доорх материалаар хүүхэлдэй болон машин урлах.

Танхимын бус үйл ажиллагаа:

- Байгалийн материалаар бүтээл хийх (унасан навч, чулуу, мөчир, боргоцой)
- Баримлын шавраар бүтээл хийх, танилцуулах.

Хөгжмийн хэмнэлд тохируулан хөдөлгөөн ба дүрийн тоглолт хийх. Суралцагч байгалийн дуу чимээ болон хөгжмийн аялгууны өнгө аясыг сонсон мэдэрч, хэмнэлт дасгал хөдөлгөөн, дуут бүжгээр илэрхийлэх бөгөөд төрсөн сэтгэгдэл, мэдрэмжээрээ дүрд тоглож сурна.

Танхимын үйл ажиллагаа:

- Хөгжмийн аялгууны өнгө аяс, хурдад тохируулан дасгал хөдөлгөөн, дуут бүжиг хийх;
- Амьтдын алхаа, хөдөлгөөнийг даган дуурайх (баавгайн алхаа, туулайн үсрэлт, шувуу нисэх гэх мэт)
- Хөгжим сонсоод төрсөн мэдрэмж, сэтгэгдлээ өнгө болон зургаар дүрслэн илэрхийлэх, бусдадаа танилцуулах.

Танхимын бус үйл ажиллагаа:

- Байгаль болон орчны дуу чимээг (шувууны жиргээ, салхины сэвшээ, усны урсгал) сонсох, амьтдын хөдөлгөөнийг ажиглах;
- Амьтны дуу хоолой болон хөдөлгөөнд хувиран жүжиглэх;
- Хөгжмийн хэмнэлд тохируулан хурдан, удаан гүйх, хоёр болон нэг хөл дээрээ үсрэх, тэнцвэрээ олох.

Дахин ашиглах материалаар хамтын бүтээл урлах. Баг хамт олноороо нэгдсэн зорилгыг тодорхойлж, дахин ашиглах болон байгалийн материал ашиглан хамтын бүтээл урлах. Хамтран бүтээх явцад гарсан давуу болон сул талыг багаараа хэлэлцэж, бүтээлийнхээ загвар ба шийдлийг дахин сайжруулж, хамтын бүтээлийн үр дүнг бусдад танилцуулна.

Танхимын үйл ажиллагаа:

- Баг бүр өөр өөр цэцэг, мод хайчлан нааж, ангийн ханын нэгдмэл том бүтээл урлах;
- Хамтран бүтээх явцад гарсан туршилт, алдааг багаараа хэлэлцэж, засан сайжруулан ангийнхандаа танилцуулах.

Танхимын бус үйл ажиллагаа:

- Багаараа цаасан салхин сэнс хийж, гадаа турших. Сэнс хэрхэн эргэж байгааг ажиглан, эргэхгүй байгаа шалтгааныг ярилцаж, засан сайжруулах;
- Сургуулийн удирдлага, багш, эцэг эхдээ хамтын бүтээлийн танилцуулга бэлтгэж сонирхуулах.

2.4. Чиглэл 3. Хамтран бүтээх, оролцох орчноо дэмжих

Зорилго: Суралцагч бусдыг сонсох, хэрэглэгдэхүүнээ хуваалцах замаар багийн тоглоом, дасгал, аялалд идэвхтэй хамтран оролцох чадварт суралцана.

Үндсэн ойлголт

Өдөр тутмын дасгал, хөдөлгөөн гимнастик хийх. Суралцагч өглөөний дасгал, хичээлийн завсарлагааны гимнастик болон хэмнэлтэй хөдөлгөөнийг өдөр тутмын амьдралдаа тогтмол хэвшүүлэн хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх дадалтай болно. Дасгал хөдөлгөөнийг бие даан болон хосоор, багаар гүйцэтгэн бие бялдрын хөгжил, уян хатан, тэнцвэр болон хөдөлгөөний эвслээ ахиулна. Дасгал хөдөлгөөн нь эрүүл мэнд, уураг тархины ажиллагаанд ямар ач холбогдолтойг ойлгож, сэтгэл хөдлөлөө эергээр илэрхийлэхэд суралцана.

Танхимын үйл ажиллагаа:

- Өглөөний дасгал, хичээлийн завсарлагааны гимнастик болон хэмнэлтэй хөдөлгөөнийг тогтмол хийх;
- Багаараа буухиа тоглоомын үйлдэл, дараалал, дүрмийг хамтран зохиож, үүргээ хуваарилан бие биеэ дэмжин тоглох.

Танхимын бус үйл ажиллагаа:

- Сургуулийн гадна талбайд цагариг, дээс ашиглан чөлөөт хөдөлгөөнт тоглоом тоглох.
- Өглөө бүр гэр бүлээрээ 5 минут хөнгөн дасгал хийж хэвших;
- Сургуулийн биеийн тамирын заал болон гадна талбайд хөдөлгөөнт ба буухиа тоглоомоор тоглох;
- Гэртээ өглөө бүр дасгал хийж, өдөр тутмын амьдралдаа идэвхтэй хөдөлгөөнийг хэвшүүлэх.

Багийн ажлын үүргийг хуваарилах, бусадтай эелдэг харилцах, идэвхтэй оролцох. Багаар ажиллахдаа хүйсийн тэгш байдал, оролцоонд суурилсан, гишүүн бүрийн давуу талд тохирсон ажил үүргийг тэгш хуваарилан идэвхтэй, хариуцлагатай оролцоно. Бусдыг хүндэтгэн сонсож, ээлжээр ярих, санал зөрөлдсөн үед асуудлыг ярилцан хамтын шийдэлд хүрэх харилцааны соёлд суралцана. Багийн гишүүд бие биеийнхээ ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрч, харилцан хамтарч ажиллана.

Танхимын үйл ажиллагаа:

- 3,4 сурагч нэг баг болж хэрэглэгдэхүүний сав хийх, ангийн номын буланг хамтран тохижуулах;
- Ангидаа сурагч бүр тодорхой үүрэг (цэцэг услах, самбар цэвэрлэх, ширээ сандлаа эмхлэх) хуваарилж ээлжлэн хийж гүйцэтгэх;
- Бусдын яриаг анхааралтай сонсож, ээлжээр ярих, санал зөрвөл эелдгээр ярилцах;
- Ангид бусдыг хүндэтгэн сонсох, ээлжээр ярих, мэндлэх, талархах, уучлалт гуйх харилцааны дүрд тоглох;
- Найздаа урам зориг өгөх эерэг үгсийн жагсаалтыг хамтдаа зохиох.

Танхимын бус үйл ажиллагаа:

- Сургуулийн гадна талбайд цэцэг, мод тарих, арчлах;

- Сургууль болон ангийн арга хэмжээнд хамт олноороо үүрэг хуваарилан идэвхтэй оролцох;
- Гэртээ аяга таваг хураах, тоглоомоо хураах өөрт тохирсон үүргийг гүйцэтгэх;
- Гэр бүл, нийгмийн орчин болон үйлчилгээний газарт (дэлгүүр, номын сан, автобус) олон нийтийн дэг журмыг сахих;
- Орон нутгийн болон сургуулийн арга хэмжээнд бусадтай соёлтой харилцаж, бие биедээ туслах;
- Ахмад настан, багш, олон нийттэй харилцахдаа хүндэтгэлийн үг хэрэглэж, харилцааны эерэг соёлыг амьдралдаа хэвшүүлэх.

Тусламж хэрэгтэй нөгөндээ туслах, бусдын ялгаатай байдлыг хүндэтгэх. Суралцагч хүн бүр ялгаатай гэдгийг ойлгож сургууль, гэр бүл болон цахим орчинд бусдын гадаад төрх, арьсны өнгө, үндэс угсаа, хөгжлийн онцлогийг хүндэтгэн, шоолохгүй, хочлохгүй, хүн бүртэй эвтэй, шударга харилцана.

Танхимын үйл ажиллагаа:

- "Бид ялгаатай - Бид тэгш" сэдэвт уриалга, зурагт санамж багаараа бүтээх;
- Ангид үл ойлголцол үүсэхэд нээлттэй, эелдгээр ярилцан шийдвэрлэх дүрмийг зохиож мөрдөх.

Танхимын бус үйл ажиллагаа:

- Багштайгаа хамт бусдыг шоолохгүй, дээрэлхэхгүй, найздаа туслахыг уриалсан зурагт хуудсыг ангидаа байрлуулах;
- Гэртээ болон сургуульдаа бусдыг шоолохгүй, хочлохгүй, хэнийг ч орхигдуулахгүйгээр хамтдаа тоглож, найрсаг харилцах.

Эрүүл мэндээ хамгаалах, ариун цэвэр ба аюулгүй байдал. Биеийн өсөлт хөгжилд өглөөний цай, шим тэжээлтэй хооллолт, тогтмол дасгал хөдөлгөөн, чанартай нойр ба өдрийн дэглэм чухал болохыг ойлгож, гар, шүд, биеийн болон хувцасны ариун цэврийг өдөр тутам сахиж хэвшинэ. Гэр ахуй, сургууль, замын хөдөлгөөн (Ногоон гэрэл, цагаан шугам) болон гадаа тоглох үеийн аюултай ба аюулгүй зүйлсийг ялган таньж, учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх дадалтай болно. Бэртэж гэмтэх, зүсэгдэх, шалбарах үед анхны тусламж (шарх боолт хийх) үзүүлэх энгийн аргад суралцаж, шаардлагатай үед 103, 102, 101, 108 тусламжийн дугаараар шуурхай дуудлага өгөх аюулгүй амьдрах ухааныг эзэмшинэ.

Танхимын үйл ажиллагаа:

- Гараа савандаж угаах, шүдээ угаах алхам дарааллыг зөв гүйцэтгэж хэвших;
- Хуруу зүсэгдэх, шалбарах, бэртэх үед анхны тусламж үзүүлэх болон 103, 102, 101, 108 дугаарт тусламж хүсэх дадлагыг хийх;
- Ангидаа явган хүний гарц загварчлан замын гэрлэн дохиогоор аюулгүй гарч сурах.

Танхимын бус үйл ажиллагаа:

- Гэртээ өглөөний цайгаа тогтмол уух, өдрийн дэглэм сахих;
- Сургуулийн үдийн цайны цагаар болон гэртээ хоолны өмнө гараа тогтмол угаах;
- Сургуулийн коридорт шахцалдаж бөөгнөрөхгүй байх, зай барьж жагсах дадалд суралцах;

- Гэрийн цахилгааны залгуур, халуун тогоотой харьцахдаа болгоомжтой байх, аюулгүй байдлыг аав ээж, асран хамгаалагчидтайгаа ярилцах.

Цахим хэрэгслийг зөв зохистой хэрэглэх Цахим орчинд дэлгэц ашиглах хугацааг зөв тохируулж, зохистой хэрэглэх дадалтай болно.

Танхимын үйл ажиллагаа:

- Цахим хэрэгслийг зөв зохистой ашиглах (гар утас,таблетын хэрэглээг хэтрүүлэхгүй байх, дэлгэцээс зайтай суух дүрмийг ярилцах).

Танхимын бус үйл ажиллагаа:

- Гэр бүлээрээ цахим хэрэглээгээ хянах (зурагт болон гар утас үзэх цагаа тодорхой хугацаагаар хязгаарлах).

2.5. Чиглэл 4. Өөрийгөө болон бусдын ажил хөдөлмөр, өв соёл, орон нутгаа танин мэдэх

Зорилго: Суралцагч монгол өв уламжлал, орон нутгийн түүхэн дурсгал, хүмүүсийн ажил хөдөлмөрийг танин мэдэж, бахархаж хүндэтгэсэн сэтгэгдлээ зураг, үгээр илэрхийлэх чадварт суралцана.

Үндсэн ойлголт

Өөрийн сонирхол, сэтгэл хөдлөлөө илэрхийлэх. Өөрт болон бусдад илэрч буй таатай (баяртай, сэтгэл хангалуун) ба таагүй (ууртай, гунигтай, айсан) сэтгэл хөдлөлийг таньж нэрлэн, хэрхэн илэрдгийг жишээгээр тайлбарлаж сурна. Таагүй сэтгэл хөдлөл, айдас, стрессээ зохицуулахын тулд дасгал хөдөлгөөн хийх, тайвшрах, амьсгалын дасгал хийх зэрэг аргыг хэрэглэх дадалд суралцана. Асуудал, бэрхшээл тулгарсан үед өөрийн мэдрэмж, хэрэгцээ, хүсэл сонирхлоо ойлгомжтой илэрхийлж, эцэг эх болон найз нөхдөөсөө тусламж, дэмжлэг хүсэж сурна.

Танхимын үйл ажиллагаа:

- "Би хэн бэ?" өөрийнхөө тухай ангийнхандаа танилцуулах;
- Сэтгэл хөдлөлийг илэрхийлсэн зурагт хуудас ашиглан өөрт болон бусдад төрсөн сэтгэл хөдлөлийг (баяртай, ууртай, гунигтай) таньж нэрлэх;
- Хөгжмийн аялгуу сонсон амьсгалын болон анхаарлаа төвлөрүүлэх дасгал хийж тайвшрах;
- Уурлах, гуниглах, айх үед мэдрэмжээ өөртөө болон бусдад төвөг учруулахгүй байхаар илэрхийлэх, тусламж хүсэх аргыг жишээ нөхцөлд тулгуурлан ярилцаж, дадлага хийх.

Танхимын бус үйл ажиллагаа:

- Асуудал бэрхшээл тулгарвал аав ээж, багш болон найздаа мэдрэмжээ нээлттэй ярьж тусламж хүсэх;
- Сургуулийн сэтгэл зүйч болон нийгмийн ажилтантай нээлттэй уулзаж сэтгэл зүйн зөвлөгөө авах.

Орон нутгийн дурсгалт газар, түүхийн музейтэй танилцах аялал. Суралцагч орон нутгийнхаа байгалийн үзэсгэлэнт газрууд болон түүхийн дурсгалт зүйлс (хадны зураг, хүн чулуу, буган чулуу), музейн үзмэрүүд, соёлын өвтэй биечлэн (аялал, экскурс) танилцаж, өнгөрсөн ба одоо үеийн хүмүүсийн амьдралын ялгааг зураг, эх сурвалжид тулгуурлан харьцуулж сурна. Нутаг усныхаа түүхээр бахархахын хамт түүх, соёлын дурсгалт зүйлсийг

хамгаалах энгийн санал, санаачилга гарган, соёлын өвийг хайрлах дадалд суралцана. Уул, усаа хамгаалах уламжлалт зан үйлд суралцаж, байгальд аялахдаа хог хаяхгүй байх, орчиндоо ээлтэй аялах дадлыг хэвшүүлнэ. Аялал зугаалгын үед аюулгүй байдлын дүрмийг мөрдөж, бие биедээ туслан хамт олны нөхөрсөг уур амьсгалыг бэхжүүлнэ.
Танхимын үйл ажиллагаа:

- Аяллын өмнө танхимд замын хөдөлгөөний болон аялахад баримтлах дүрмийг, зураг ашиглан ярилцах;
- Аяллаар ажигласан мод, цэцэгсээ зургаар илэрхийлэн үзэсгэлэн гаргах;
- Орон нутгийн хадны зураг, хүн чулуу, буган чулуу, музейн үзмэрийн зургийг ажиглаж, дүрсэлсэн зүйл, өнгө, хэлбэрийн талаар ярилцах;
- Багшийн үзүүлсэн хуучны болон өнөөгийн хувцас, сууц, ахуйн хэрэгслийн зургийг ажиглаж, ижил ба өөр зүйлийг олж, юунд хэрэглэдгийг тайлбарлах;
- "Манай нутгийн дурсгал" хамтын зургийн цомог бүтээж, хүүхэд бүр сонирхсон дурсгалаа зурж, нэг өгүүлбэрээр танилцуулах.

Танхимын бус үйл ажиллагаа:

- Орон нутгийн цэцэрлэгт хүрээлэн, хөшөө дурсгал бүхий газраар аялах, танин мэдэх;
- Сургуулийн хашаан дахь мод, цэцэгстэй танилцаж, хөрс болон навчийг ажиглах;
- Сургууль орчим, цэцэрлэгт хог хаягдлыг хогны саванд ангилан хаях, ил задгай хог хаяхгүй байхад сургах;
- Багш, эцэг эхийн хамт орон нутгийн музей, соёлын төвийн өвийн булан эсвэл ойр орчмын дурсгалт газарт очиж, чиглүүлэх асуултын дагуу ажиглах;
- Музейн хуучны ахуйн хэрэгслээс нэгийг сонгон ажиглаж, өнөөдөр хэрэглэдэг ижил зориулалттай зүйлтэй нь харьцуулан ярилцах;
- Музейн ажилтан эсвэл нутгийн ахмад хүнээс "Энэ зүйлийг юунд хэрэглэдэг байсан бэ?", "Яагаад хамгаалах хэрэгтэй вэ?" гэж асууж, мэдсэн зүйлээ найзууддаа хуваалцах;
- Аяллын үеэр дурсгалд хүрэхгүй, дээр нь бичихгүй, орчныг бохирдуулахгүй байх дүрмийг мөрдөж, хамгаалах энгийн үйлдэлд оролцох.

Монгол өв уламжлал, ахуйн соёлтой танилцах. Суралцагч монгол гэрийн бүтэц, гэрт баримтлах дэг ёс, цээрлэх зүйлс болон үндэсний дээл хувцсаа хүндэтгэн эвхэж хэрэглэх зан үйлд суралцана. Цагаан сар, наадмын уламжлалт ёс, таван хошуу малын ашиг шим, үндэсний өв соёлоороо бахархана.

Танхимын үйл ажиллагаа:

- Монгол гэрийн зураг, жижиг загварыг ажиглаж, хана, унь, тооно, хаалга зэрэг үндсэн хэсгийг таньж нэрлэх;
- "Монгол гэрт зочилъё" дүрд тоглох үйл ажиллагаагаар мэндлэх, босгон дээр гишгэхгүй байх, эд зүйлсийг зөвшөөрөлтэй хэрэглэх зэрэг дэг ёсыг дадлагажуулах;
- Дээл, бүс, малгайг ажиглан нэрлэж, дээлийг багшийн дэмжлэгтэй эвхэж, цэгцтэй байрлуулах;
- Таван хошуу малын зураг, тоглоомыг нэрлэж, сүү, ноос, ноолуур зэрэг ашиг шимийн зурагтай тохируулан холбох;
- Шагайн тоглоомыг дүрмийн дагуу хамтран тоглож, уламжлалт тоглоомоор тоглосон сэтгэгдлээ хуваалцах.

Танхимын бус үйл ажиллагаа:

- Цагаан сар, наадмын ёс заншилтай танилцаж, сургууль болон гэр бүлийн орчинд уламжлалт шагайн наадам, хөлөгт тоглоом тоглох;
- Багш, эцэг эхийн хамт монгол гэр, музейн монгол ахуйн буланд зочилж, гэрийн бүтэц, эд хэрэгслийг ажиглан, юунд хэрэглэдгийг асууж мэдэх;
- Гэр бүлийнхэнтэйгээ дээл хувцсаа эвхэж, хадгалах газарт нь цэгцтэй байрлуулах дадлыг хэрэгжүүлэх;
- Гэр бүлийнхэнтэйгээ цагаан идээтэй танилцаж, нэрлэх, ямар малын сүүгээр хийдгийг асууж мэдэх.

Орон нутгийн хүмүүсийн ажил хөдөлмөрийн онцлогтой танилцах. Суралцагч аав ээж, гэр бүлийн гишүүд болон орон нутгийн хүмүүсийн хийж буй ажил хөдөлмөр, аж ахуйн онцлогтой танилцаж, тэдний ажил хөдөлмөрийн ач холбогдлыг ойлгож хүндэтгэнэ. Эрдэм сурах болон хөдөлмөрлөхийн ач тусыг ухамсарлана. Мөн гэрийн болон сургуулийн орчинд өөрт ноогдсон ажлыг хариуцлагатай гүйцэтгэх хөдөлмөрч дадлыг хэвшүүлнэ.

Танхимын үйл ажиллагаа:

- “Би том болоод...” дүрд тоглох үйл ажиллагаагаар төрөл бүрийн ажил мэргэжлийн онцлогийг үзүүлж, хүмүүсийн амьдралд ямар ач тустайг ярилцах;
- Сургуулийн эмч, номын санч, тогооч, үйлчлэгч нарын хөдөлмөрийн онцлогийг зургаар үзэж, талархлын зураг зурж бэлэглэх.

Танхимын бус үйл ажиллагаа:

- Эцэг эх, асран хамгаалагч нарынхаа ажлын байртай танилцах;
- Гэртээ болон сургуульдаа өөрт ноогдсон цэвэрлэгээ, тохижилтын ажлыг хариуцлагатай гүйцэтгэж, хөдөлмөрч дадалд суралцах.

Дээрх агуулгын чиглэл, жишиг үйл ажиллагааг судлагдахуунуудын интеграци агуулгатай уялдуулан хэрэгжүүлнэ.

2.6. Бүтээлч үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга зүй

Бүтээлч үйл ажиллагааны үндсэн арга зүй нь суралцагчдад бодит зүйлс, орчин, хэрэглэгдэхүүнийг гараар барьж, нүдээр харж, ажиглан турших замаар асуудлыг бие даан болон багаар шийдвэрлэхэд чиглэнэ. Энэхүү арга зүй нь суралцагчдад мэдлэгээ амьдралын бодит нөхцөлтэй холбох, туршилтын явцад гарсан алдаанаас суралцан бүтээл ба шийдлээ дахин туршиж засан сайжруулах, хамтран суралцах болон өөрийгөө бүтээлчээр илэрхийлэх боломжийг олгодог давуу талтай.

"Бүтээлч үйл ажиллагааны таван үе шат" бүхий загвараар бүтээлч үйл ажиллагааг төлөвлөн зохион байгуулна.



Зураг 3. Бүтээлч үйл ажиллагааны арга зүйн алхам.

Сонирхох, асуух. Суралцагчид хүрээлэн буй орчны бодит зүйлс, зураг, тоглоом болон гэр, сургуулийн орчинд тулгамдсан асуудлыг сонирхон ажиглаж, "Хэн?, Юу?, Яагаад?, Яаж?" гэсэн асуултуудыг асууна. Суралцагчид ажигласан зүйлийнхээ талаар юу мэддэг, юуг шинээр хийх эсвэл өөрчлөх шаардлагатай байгааг тодруулна.

Санаа гаргах, сонгох, төлөвлөх. Суралцагчид тухайн асуудлыг шийдвэрлэх эсвэл бүтээл хийх боломжит санаа, таамаглалыг багаар болон бие даан гаргаж ярилцана. Багшийн чиглүүлэгтэй гаргасан санаануудаас хамгийн тохиромжтой шийдлийг сонгож, хийх ажлын дараалал, шаардлагатай хэрэглэгдэхүүн болон багийн гишүүдийн үүрэг оролцоог хуваарилан төлөвлөнө.

Судлах турших, бүтээх. Суралцагчид бодит материал, багаж хэрэгсэл ашиглан, ажиглалт хийх, хэмжих, угсрах, зурах, наах, туршилт болон тоглоомд оролцоно. Тэд сонгосон санааныхаа дагуу үйл хийх, бүтээл хийх замаар асуудлыг шийдвэрлэхэд суралцана.

Шалгах, өөрчлөх, сайжруулах. Бүтээсэн зүйл эсвэл гаргасан санаа шийдэл нь хэрэгжиж байгаа эсэх, анхны санаа зорилгод нийцсэн эсэхийг ажиглаж, туршин шалгана. Хэрэв туршилтын явцад алдаа эсвэл тохиромжгүй зүйл гарвал материал, хэлбэр, дараалал, дүрмээ засан өөрчилж, дахин туршиж, сайжруулна.

Хуваалцах, эргэцүүлэх. Суралцагчид хийсэн бүтээл, олж авсан туршлага, ашигласан арга, амжилттай болсон зүйлийг бусдад тайлбарлан, яриа, хөдөлгөөн, зураг, ханын самбарын илтгэлээр нээлттэй хуваалцана.

Бүтээлч үйл ажиллагааны зорилгод нийцүүлэн бага боловсролын сургалтын хөтөлбөрт тусгасан тоглоомд суурилсан арга зүй, зохиолд суурилсан арга зүй, шинжлэн судлах арга зүй, асуудал шийдвэрлэх арга зүй, төсөлд суурилсан арга зүйг уян хатан хослуулан хэрэглэнэ.

Тоглоомд суурилсан арга зүй: Суралцагч өөрөө бие даан тоглох явцдаа мэдлэг, ур чадвар эзэмших эсвэл багшийн тусламжтайгаар тоглоомын арга хэрэглэн боловсрол эзэмших гэсэн 2 боломжийг олгодог. Тоглоомд суурилсан сургалт нь бие бялдрын тоглоом, хөдөлгөөн, эрэл хайгуул, асуудлыг шийдвэрлэхэд анхаардаг суралцахуй юм. Суралцагчийн сонирхол, бүтээлч байдал, нийгэмшихүй, асуудал шийдвэрлэх чадварыг хөгжүүлдэг.
Жишээ: "Дэлгүүр" тоглоом ба ухаалаг хэрэглээ

Тоглоомын дүрэмтэй танилцах: "Дэлгүүр" тоглоомын зорилготой танилцаж, сурагч бүр тодорхой мөнгөн дэвсгэртээр (цаасан мөнгө) хичээлийн хэрэгслээ төлөвлөн худалдан авах дүрэмтэй танилцана. Худалдагч ба худалдан авагчийн харилцааны соёл, аюулгүй байдал, тоглоомын талаарх ярилцана.
Тоглох, гүйцэтгэх: Сурагчид худалдагч ба худалдан авагчийн дүрд хувирч, мөнгөө зөв тоолон хэрэгцээт хичээлийн хэрэгслээ сонгон худалдан авалт хийнэ.
Тоглоомыг дүгнэх: Тоглоомд оролцсон мэдрэмж, сэтгэгдлээ хуваалцаж, хэн мөнгөө хэрэгцээт зүйлдээ зөв зарцуулж чадсаныг ярилцан, бусдадаа танилцуулна.

Зохиолд суурилсан арга зүй: Эх зохиолоор дамжуулан үг, өгүүлбэрийг зөв уншихын зэрэгцээ утгыг нь ойлгох чадвар, хөгжмийн зохиолоор дамжуулан өмнөх туршлагаасаа суралцан шинэ ур чадвараа хөгжүүлэх, мэдрэмж, санаа бодол, сэтгэл хөдлөлөө илэрхийлэх, сэтгэн бодох, үнэлэх чадварыг хөгжүүлэхэд чиглэдэг.
Жишээ: "Зурагт ном ба цаасан хүүхэлдэйн жүжиг"
Зохиолоо сонгох, төлөвлөх: Асран хамгаалагчийн хамт сургуулийн болон орон нутгийн номын сангаар зочилж, 6 настай хүүхдийн сонирхолд тохирсон, дүрүүдийн сайн ба муу үйл явдалтай зурагт номыг сонгоно.
Уншиж ойлгох: Сонгосон зурагт номоо гэр бүлээрээ уншиж, үйл явдлын агуулга, дүрүүдийн зан чанарыг ойлгон ярилцаж, шинэ үгсийн утгыг тогтооно.
Идэвхтэй оролцох, хэлэлцэх: Зохиолын гол санаа, дүрүүдийн үйлдэл, сайн ба муу талуудыг эцэг эх, асран хамгаалагчтайгаа ярилцаж, өөрийн бодлоор үнэлнэ.Тухайн уран бүтээлийн гол санаа, үг хэллэг, дүр, үйл явдал, сэдвийн талаар хосоор, бүлгээр хэлэлцэх;
Бүтээлчээр илэрхийлэх, дүгнэх: Номоос ойлгосон зүйлээрээ цаасан хүүхэлдэй хийж, багш болон ангийнхандаа бяцхан жүжигчилсэн тоглолтоор үзүүлж, төрсөн мэдрэмжээ илэрхийлнэ.

Шинжлэн судлах арга зүй: *Танил орчны бодит юмс, байгалийн үзэгдлийн талаар таамаглал дэвшүүлэх, эрэл хайгуул хийх боломжийг олгодог арга зүй юм.*

Жишээ: "Миний усан онгоц усанд хөвөх үү?" (гэртээ усан онгоц бүтээж турших)

Асуулт асуух,таамаглал дэвшүүлэх: Хүүхэд гэртээ байгаа дахин ашиглах боломжтой материалыг(хөөсөнцөр, хуванцар сав, өнгөт цаас, баримлын шавар, модон саваа) ажиглаж, *"Эдгээрийн аль нь усанд сайн хөвөх усан онгоц болж чадах вэ?", "Усан онгоцон дээр бяцхан тоглоом суулгавал живэх үү?"* гэсэн асуулт асууна.

Туршилт, үйл ажиллагааг төлөвлөх: Асран хамгаалагчийн дэмжлэгтэйгээр савтай ус бэлтгэж, усан онгоц хийх материалаа (ундааны сав, соруул, скоч, резин) цуглуулж, ямар дарааллаар онгоцоо угсарч туршихаа төлөвлөнө. *(Аюулгүй байдлын үүднээс ус асгахгүй байх, хайч хэрэглэхдээ болгоомжтой байх дүрмийг тохирно).*

Турших, өгөгдөл цуглуулах, задлан шинжлэх: Сонгосон материалаараа гэртээ бяцхан усан онгоц зохион бүтээж, савтай усанд хийн хөвүүлж туршина. Усан онгоцон дээрээ жижиг тоглоом суулган хэдэн тоглоом дааж байгааг тоолж, усанд суулт өгч байгаа эсэхийг ажиглан, зургаар ажлын хуудсанд тэмдэглэнэ.

Үр дүнг боловсруулах, нягтлах: Усан онгоц нь хөвж чадсан уу, эсвэл живсэн үү гэдгийг ажиглан анхны таамаглалтайгаа харьцуулна. Хэрэв онгоц хазайж байвал ёроолд нь баримлын шавраар ачаа тохируулан тэнцвэржүүлэх эсвэл далбааг нь янзлан засан сайжруулж, үр дүнгээ дахин нягтална.

Үр дүнг бусдад тайлбарлах: Гэртээ хийсэн усан онгоцныхоо зургийг авч эсвэл хичээл дээр авчирч, *"Миний усан онгоц ямар материалаар хийгдсэн, хэдэн тоглоом дааж хөвсөн бэ"* гэдгийг ангийнхандаа болон багшдаа тайлбарлан танилцуулна.

Асуудал шийдвэрлэх арга зүй: Суралцагчид бодит амьдрал, анги, сургууль болон ойр орчинд тулгардаг хүүхдийн насанд тохирсон асуудал, нөхцөл байдлыг ажиглан, асуудлыг тодорхойлох, санаа гаргах, шийдлээ сонгох, хэрэгжүүлэх, үр дүнгээ хуваалцах замаар суралцах арга зүй. Багш бэлэн шийдэл өгөхөөс илүү асуулт, зурагт нөхцөл, бодит ажиглалт, хэрэглэгдэхүүнээр суралцагчийн үйл ажиллагааг чиглүүлнэ.

Жишээ: "Сургуулийн аюулгүй замын тэмдэглэгээ"

Асуудалтай танилцах: Багштайгаа хамт сургуулийн коридор, шат, гадна талбайгаар ажиглалт хийж, хүүхдүүд бөөгнөрдөг, гүйж байгаад унах эрсдэлтэй аюултай хэсгүүдийг илрүүлэн асуудал болгон дэвшүүлнэ.
Асуудлыг ойлгох, төлөвлөх: "Шат ба коридорт яаж аюулгүй зорчих вэ?" гэдгийг ойлгож, анхааруулах болон чиглүүлэх зурагт тэмдэг хийх төлөвлөгөө багаараа боловсруулна.
Асуудлыг шийдэх: Сурагчид багаараа "Баруун гараа барь", "Гүйж болохгүй", "Зай барь" гэсэн зурагт анхааруулга бэлтгэж, сургуулийн аюултай хэсгүүдэд байршуулна.
Шийдлийг танилцуулах, эргэцүүлэх: Бэлтгэсэн зурагт тэмдгээ сургуулийн бусад ангийнханд танилцуулж, аюулгүй зорчиход тусалж байгаа эсэхийг ажиглан эргэцүүлнэ.
Нэгтгэн дүгнэх, үнэлэх: Сургуулийн коридорын хөдөлгөөн цэгцтэй болсон эсэхийг шалгаж, хамгийн ойлгомжтой, сайн тэмдэглэгээг сонгон дүгнэнэ.

Төсөлд суурилсан арга зүй: Анги сургууль, байгаль орчноо хамгаалах, хог хаягдлыг ангилах, дахин ашиглах тодорхой зорилтот бяцхан төслийг багаараа төлөвлөн, үүрэг хуваарилан хамтын бүтээл хийх арга зүй юм.

Жишээ: "Бяцхан хэмнэгч-Мөнгөний хуримтлалын хайрцаг бүтээх"

Төслийн санаа олох: Хичээлийн хэрэгсэл, задгай мөнгөө дэмий үрэхгүй ариглах хэрэгцээг ярилцаж, ашигласан цаасан аяга ба хайрцаглаа ашиглан "Мөнгөний хуримтлалын хайрцаг хийх" төслийн санааг сонгоно.

Бүтээгдэхүүний шинжилгээ хийх: Бэлэн мөнгөний хайрцаг болон задгай мөнгө хийдэг савнуудыг ажиглаж, мөнгө оруулах зангилаа нүх, эвдрэхгүй байх чанар, тагны бүтцийг шинжиж мэдээлэл цуглуулна.
Мэдлэг бүтээх: Бага багаар хуримтлуулсан задгай мөнгө хэрэгцээт хичээлийн хэрэгслээ худалдан авахад ач холбогдолтойг ойлгож, цаасан аягыг хоёр давхарлавал бат бөх болдог мэдлэг бүтээнэ.
Шинэ санаа боловсруулах: Дахивар цаасан аяга, хайрцаг, өнгөт цаас ашиглан өөрийн сонирхсон хэлбэртэй (жишээ нь: заан эсвэл байшин хэлбэртэй) хуримтлалын 3 хэмжээст хайрцаг урлах шинэ санаа дэвшүүлнэ.

Эргэцүүлэх: Хайрцагтаа задгай мөнгө хийж турших бөгөөд мөнгөний нүх багадсан эсвэл нурж байвал бэхэлгээг дахин нааж засан сайжруулж, эцсийн бүтээлээ ангийнхандаа үзүүлнэ.

2.7. Явцын үнэлгээ, баримтжуулалт

Бүтээлч үйл ажиллагааны үнэлгээ нь суралцагчийн оролцоо, санаа, сонголт, мэдлэг, чадвараа хэрэглэж буй байдал, судлах, турших, хамтран ажиллах, дахин оролдож сайжруулах ахицын талаар мэдээлэл цуглуулж, дараагийн үйл ажиллагааг багшийн дэмжлэг, орчин, хэрэглэгдэхүүн, тохируулгыг сайжруулахад чиглэнэ.

Үнэлгээнд дараах үндсэн баримтаас зорилгод тохирохыг нь сонгон ашиглана. Үүнд:

- Өдөр тутмын ажиглалт;
- Суралцагчийн асуулт, санаа, тайлбар;
- Бүтээл, загвар, эхний болон сайжруулсан хувилбар;
- Хос, бүлгийн үйл ажиллагаан дахь оролцоо;
- Суралцагчийн насанд тохирсон өөрийн үнэлгээ.

Нэг бүтээлч үйл ажиллагаагаар бүх үр дүнг ажиглахгүй. Тухайн үйл ажиллагааны зорилготой холбоотой нэгээс гурван чиглэлийг сонгож, өөр өөр хугацаа, орчин, үйл ажиллагаанд цугларсан баримтыг хамтатган авч үзнэ.

Бүтээлийн хавтас

Энэ нь суралцагчийн хийсэн бүх цаасан ажил, зургийг цуглуулсан эмхэтгэл биш бөгөөд харин суралцагчийн суралцах явц, ахиц дэвшил, анхны болон сайжруулсан хувилбарын өөрчлөлтийг харуулах зорилгоор сонгосон бүтээл, баримтын (өөрийн үнэлгээний хуудас, багшийн ажиглалтын тэмдэглэл, багшийн санал зөвлөмж, фото зураг) бүрдэл байна.

Жишээ 1.Бүтээлийн хавтасны бүтэц:

1. Хавтасны нүүр: Суралцагчийн овог нэр, сургууль, анги, бүлэг, хичээлийн жил, удирдан чиглүүлсэн багш, эцэг эх/ асран хамгаалагч, хавтас нээсэн огноо гэх мэт
2. Миний танилцуулга: миний дуртай зүйлс, миний мөрөөдөл
3. Сонгосон бүтээлүүд:
   - Бүтээлийн эхний хувилбар;
   - Туршилтын явцад засаж сайжруулсан 2 дахь хувилбар (зураг, бүтээл, ажлын хуудас);
   - Тухайн бүтээлд өгсөн багшийн санал, зөвлөмж ба суралцагчийн өөрийн үнэлгээний хуудас.

Хүснэгт 2. Бүтээлийн хавтасны бүртгэлийн хуудас

№	Сэдэв	Бүтээлийн төрөл	Эхний хувилбар (Огноо)	Сайжруулсан хувилбар (Огноо)	Юуг өөрчилж, хэрхэн сайжруулсан баримт
1		.....	.....	.....	.....
2					

Жишээ 2. Өөрийн үнэлгээний хуудас

Суралцагч өөрийгөө бусадтай харьцуулах биш өөрийн ололт амжилт, сурсан үр дүн, санаа гаргасан байдал, алдаанаасаа суралцаж буй байдал, бүтээлээ сайжруулахад чиглэх үнэлгээ болно.

Багш сонголт бүрийн утгыг энгийн үгээр тайлбарлан уншиж өгнө. Суралцагч хийсэн ажлаа эргэцүүлж, өөрт тохирох нэг сонголтын нүдэнд ✓ тэмдэг зурна.

Суралцагчийн нэр: ..... Анги: ..... Огноо: .....

Миний өөртөө өгөх үнэлгээ	[ ] Маш сайн хийсэн	[ ] Сайн хийсэн 	[ ] Улам хичээнэ

Өнөөдрийн бүтээлийн хамгийн чухал хэсэг юу байсан вэ?
Хариулт.....
Бүтээлийн хамгийн таалагдсан хоёр зүйлийг нэрлээрэй
Хариулт.....

"Би юуг, яаж сурав" арга

Би юуг сурав	Би үүнийг яаж сурав
.....	.....
.....	.....

Жишээ 3. Багшийн ажиглалтын тэмдэглэл

Багш тухайн хичээлээр ажиглах 1–3 хүрэх үр дүнгийн чиглэлийг (✓) дагуу ажиглалт хийж тэмдэглэл хөтөлнө. Суралцагчийн хийсэн тодорхой үйлдэл, гарсан ахиц, багшийн хийсэн тохируулгыг товч бөгөөд бодитой тэмдэглэнэ.

Сэдэв: ..... Огноо: ... он ... сар ... өдөр

Ажиглахаар сонгосон хүрэх үр дүнгийн чиглэл (1–3-ыг сонгоно):

- ( ) Санаа гаргах, сонголт хийх, төлөвлөх
- ( ) Асуух, судлах, турших, мэдлэг чадвараа хэрэглэх
- ( ) Бүтээх, турших, сайжруулах (дахин оролдох)
- ( ) Харилцах, хамтран ажиллах, үүрэг биелүүлэх
- ( ) Хийснээ дахин сайжруулах, дэг мөрдөх, хэрэглэгдэхүүн хураах

№	Сурагчийн нэр	Ажиглагдсан бодит үйл	Гарсан ахиц, сайжруулсан хувилбар	Багшийн дэмжлэг
1	Сурагч 1	.....	.....	.....

Жишээ 4. Багшийн санал, зөвлөмж

Багшийн суралцагчид өгөх санал, зөвлөмж нь товч, ойлгомжтой, хийсэн үйл, оролдлого, ахицад тулгуурласан, дараагийн алхмыг чиглүүлсэн байна. Ямар санаа гаргасан, ямар арга туршсан, хэрхэн хамтарсан, юуг өөрчилсөн талаар тодорхой мэдээлнэ.

БАГШИЙН САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Суралцагчийн нэр: ..... Огноо: .....

Сэдэв: .....

1. Суралцагч ямар шинэ санаа, шийдэл гаргасан бэ?

.....

2. Санаа шийдлээ хэрхэн туршиж, ямар давуу болон сул тал ажиглагдсан бэ?

.....

3. Суралцагч бусадтай хэрхэн хамтарч ажилласан бэ?

.....

4. Дараагийн алхамд юуг, хэрхэн сайжруулах вэ? (зөвлөмж)

.....

Гарах тасалбар арга

Миний өнөөдөр сурсан 2 зүйл	Надад сонирхолтой санагдсан 2 зүйл	Надад 1 асуулт байна
.....	.....	.....
.....	.....	.....

Суралцагчид өгөх санал зөвлөмж нь товч, ойлгомжтой, хийсэн үйл, оролдлого, ахицад тулгуурласан, дараагийн алхмыг чиглүүлсэн байна. Ямар санаа гаргасан, ямар арга туршсан, хэрхэн хамтарсан, юуг өөрчилсөн талаар тодорхой мэдээлнэ.

Бүтээлийн хавтсыг бүх ажлыг хадгалах цуглуулга бус суралцагчийн үйл явц, ахиц, сайжруулалтыг харуулах сонгосон баримтын бүрдэл болгон ашиглаж болно.

2.8. Хэрэгжилт, зохион байгуулалт

Сургалтын менежер, нэгдүгээр ангийн багш нар "Бүтээлч үйл ажиллагаа"-ны жилийн төлөвлөлтийг хамтран боловсруулна. Төлөвлөлтөд тухайн улирлын цаг, сэдэв, гол асуулт, асуудал, холбогдох суралцахуйн үр дүн, дэмжих чадамж, суралцагчийн хийх үйл, орчин, хэрэглэгдэхүүн, аюулгүй байдал, тохируулга, явцын үнэлгээг тусгана.

Жилийн төлөвлөлтийг нэг төрлийн үйл ажиллагаа, тоглоом, хэрэглэгдэхүүнээр бүхэлд нь зохион байгуулахгүй. Судлах, турших, зохион бүтээх, урлаг, хөдөлгөөн, тоглоом, хамтран бүтээх, өв соёл, байгаль, орон нутгийн агуулгыг тэнцвэртэй хангана.

Үйл ажиллагааг:

- 35 минутын нэг ээлжит хичээл;
- Завсарлагатай дараалсан хоёр ээлжит хичээл;
- Хэд хэдэн ээлжит хичээлээр үргэлжлэх бичил төсөл хэлбэрээр зохион байгуулж болно.

Ээлжит хичээлийг сонирхол өдөөх, санаа гаргах, судлах-турших-бүтээх, хуваалцах-эргэцүүлэх үндсэн алхам дарааллаар суралцагчийн нас, анхаарал, оролцоонд нийцүүлэн уян хатан зохион байгуулна. Хичээлийн жилийн эхний дөрвөн долоо хоногт сургууль, ангийн орчинд дасан зохицохыг дэмжсэн үйл ажиллагааг сонгон хэрэгжүүлж болно. Тухайлбал, ангийн таних тэмдэг бүтээх, сургууль дотор зорчих замтай танилцах, хэрэглэгдэхүүний байрлалыг тогтоох, ангийн зураг дүрэм боловсруулах, найзтайгаа хамтран бүтээх, мэдрэмжээ дүрслэх, аюултай ба аюулгүй орчныг ялгах үйл ажиллагааг зохион байгуулна.

Сургууль, багш нь орон нутаг, сургуулийн нөхцөл, суралцагчийн хэрэгцээнд нийцүүлэн сэдэв, үйл ажиллагааны дараалал, орчин, хэрэглэгдэхүүнд тохируулга хийж болно. Ингэхдээ батлагдсан цагийн хуваарилалт, зорилго, нийтлэг зарчмыг баримталж, суралцагч бүрийн тэгш оролцоо, аюулгүй байдлыг ханган хэрэгжүүлнэ. Бүтээлч үйл ажиллагааны цагийг сургалтын агуулгыг давтах, хоцрогдол нөхөх, шалгалтад бэлтгэх, бүх суралцагчдаар ижил загварын бүтээл хийлгэх, секц, дугуйлан, уралдаанаар орлуулах цаг болгон ашиглахгүй байхыг анхаарна.

ХАВСРАЛТ. НЭГДҮГЭЭР АНГИЙН “БҮТЭЭЛЧ ҮЙЛ АЖИЛЛАГАА”-НЫ ТӨЛӨВЛӨЛТ, ЖИШИГ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Хүснэгт 3. Бүтээлч үйл ажиллагааны жилийн төлөвлөлтийн жишиг

Улирал	I улирал									II улирал									III улирал										IV улирал										Нийт хугацаа (долоо хоног)
Сар	9 сар				10 сар					11 сар				12 сар					1 сар				2 сар				3 сар				4 сар				5 сар					
Долоо хоног	I	II	III	IV	V	I	II	III	IV	I	II	III	IV	V	I	II	III	IV	I	II	III	IV	I	II	III	IV	V	I	II	III	IV	I	II	III	IV	V	I	II	III	IV	
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	22	23	24	25	26	27	28	29	30	31	32	33	34	35	36	37	38	39	40	
I анги	СДЗҮА (8ц)				БҮА (10 ц)				А	БҮА (16 ц)								БД	А	БҮА (16 ц)								БД	А	БҮА (14 ц)								А	64 ц	

Тэмдэглэгээ: БҮА- Бүтээлч үйл ажиллагаа, СДЗҮА - Сургуульд дасан зохицох үйл ажиллагаа, А - Амралт

Тайлбар: Бүтээлч үйл ажиллагааг 7 хоногт 2 цаг байхаар төлөвлөн зохион байгуулна. Энэхүү жишиг төлөвлөгөөг Боловсролын сайдын “Хичээлийн жилийн бүтэц шинэчлэн батлах тухай” А/211 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралт дахь нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн жилийн бүтцэд үндэслэн боловсруулсан бөгөөд орон нутгийн сургуулиуд өөрийн хичээлийн жилийн бүтцэд нийцүүлэн тохируулж хэрэгжүүлнэ.

Нэгдүгээр ангид бүтээлч үйл ажиллагааг жилийн хугацаанд нийт 64 цагаар хэрэгжүүлэх бөгөөд үүнээс эхний 4 долоо хоног 8 цаг сургуульд дасан зохицох үйл ажиллагаатай уялдуулан зохион байгуулна. Бие даасан хөтөлбөртэй Шатар, STEAM-д суурилсан үйл ажиллагааг хүрэх үр дүн, агуулгын чиглэлтэй уялдуулан сонгон хэрэгжүүлж болно.

Хүснэгт 4. Бүтээлч үйл ажиллагааны агуулгын жишиг төлөвлөлт

Улирал	Ч1. Судлах, турших, асуудал шийдвэрлэх, зохион бүтээх				Ч2. Хэл, урлаг, хөгжим, хөдөлгөөнөөр бүтээлчээр илэрхийлэх				Ч3. Хамтран бүтээх, оролцох, орчноо дэмжих				Ч5. Өөрийгөө болон бусдын ажил хөдөлмөр, өв соёл, орон нутгаа танин мэдэх			
	Сургууль ба орчны тулгамдсан асуудлыг шийдвэрлэх бичил төсөлт ажил хийх	Өрхийн болон өөрийн санхүүгийн хэрэглээг зөв зарцуулах	Сургуулийн орчинд ажиглалт хийж амьд биесийг бүртгэх, тоолж харьцуулах	Дахин ашиглах материал болон STEAM хэрэглэг дэхүүнээр зохион бүтээж, турших	Бүтээлчээр унших, өөрийн санаа бодлоо илэрхийлэх	Дахин ашиглах материалаар хамтын бүтээл урлах	Хөгжмийн хэмнэлд тохируулан хөдөлгөөн бадүрийн тоглолт хийх	Зураг зурах, хамтын бүтээл урлах	Өдөр тутмын дасгал, хөдөлгөөн, гимнастик хийх	Эрүүл мэндээ хамгаалах, ариун цэврийг сахих, аюулгүй байдлаа хангах,цахим хэрэгслийг зөв зохистой хэрэглэх;	Багийн ажлын үүргийг хуваарилах, бусадтай эелдэг харилцах, идэвхтэй оролцох	Тусламж хэрэгтэй хэн нэгэндээ туслах, бусдын ялгаатай байдлыг хүндэтгэх	Өөрийн сонирхол, сэтгэл хөдлөлөө илэрхийлэх, "Би хэн бэ?" танилцуулга хийх;	Орон нутгийн байгалийн үзэсгэлэнт газар, дурсгалт газар, түүхийн музейтэй танилцах	Монгол өв уламжлал, ахуйн соёлтой танилцах	Орон нутгийн хүмүүсийн ажил хөдөлмөрийн онцлогтой танилцах
I улирал	Гэрлэн дохиогоор ангийн дуу чимээ зохицуулах		Сургууль орчны аюултай зүйлийг ажиглаж, тэмдэг байршуулах		Сургуулийн номын сангаар зочилж унших	'Бид нэг ангийнхан' (Навч, гарын хээгээр мод хийх)	'Хөгжимт хөдөлгөөн'	'Хамтдаа бүтээсэн зураг'	Завсарлагааны хөгжимт дасгал сурах	'Бидний дэг' (Зураг дүрэм) Сургууль дотор аюулгүй зорчих дараалал	Багаар ажиллах ангийн карт байгуулах	Ангийн хүүхдүүдийн ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрөх	'Би хэн бэ?' өөрийгөө танилцуулах		Аав, ээжийн сурч байсан сургуультай танилцах	
II улирал	Хог хаягдлыг ангилах 3 хэмжээст хайрцаг урлах	Бяцхан хэмнэгч (Гэрийнхэнтэйгээ хуримтлалын хайрцаг хийх)		'Өвлийн орчин' Салхин сэнс хийж турших	Үлгэрийн баатрудын дүрд тоглох	Дахин ашиглах материалаар ангичимэглэх	Хөгжим сонсож мэдрэмжээ зургаар илэрхийлэх	Цас, өвлийн байгаль зурах			'Нөхөрсөг харилцаа' (Багаар хамтрах)	Найздаа туслах эерэг үйлийн аян		'Музейн аялал' (Орон нутгийн музей)	'Монгол гэр угсрах' • Цагаан сарын золгох ёс, дэг	

III улирал	Шувууны тэжээгч сав хийж моддод байршуулах	'Дэлгүүр' тоглоом (Мөнгөн дэвсгэрт, худалдаа)	Өвлийн шувуудба цасны бүтэц ажиглах	'Чарга угсрах' (STEM, татах хүч) • Усан онгоц бүтээж хөвүүлэх туршилт		'Миний бяцхан найз' (Хүүхэлдэй урлах)	Хүүхэлдэйн зан төрхийг хөдөлгөөнөөр үзүүлэх	'Миний мөрөө дөл' зураг зурах	Өвлийн агаарт биеийн тамирын тоглоом	Цахим хэрэгслийн зохистой хэрэглээ	Туршилт ажлын багт үүрэг хуваарилах	Бяцхан найздаа болон амьтдад туслах сэтгэл		Цэцэрлэгт хүрээлэнгээр аялах		Аав, эзэжийн хөдөлмөрийн онцлог ярилцах
IV улирал	Ангид ногоон булан (тасалгааны ургамал) арчлах		'Манай сургуулийн орчны амьд байгалийн зурагла л	'Машины хөдөлгөөнт загвар хийж турших'	Бүтээлийнхээ тайлбар, түүхийг бэлтгэж ярих	Байгалийн материалаар хийсэн наамал	Ангиаа 'Амьд байгаль' сэдэвт хөгжимт жүжиг	Гадаа талбайд байгалийн зураг зурах	Гадаа талбайд бөмбөг, дээсээр тоглох	'Бидний бүтээл' тайлан үзэсгэлэн гаргах	Сургуулийн ногоон байгуулмжид хамтран оролцох	Өөрийн болон бусдын бүтээлийг сайшаан урамшуулах	'Би том болоод...' ажил мэргэлийн дүрд тоглох	Сургууль орчмын түүхэн ба үзэсгэлэнт газартай танилцах	Гадаа талбайд үндэсний ба хөлөгт тоглоом тоглох	Орон нутгийн мэргэжилтнүүдтэй уулзах

Тайлбар:

Танхимын бус үйл ажиллагаа	Танхимын үйл ажиллагаа	Танхимын болон танхимын бус хосолсон үйл ажиллагаа

Санамж: Дээрх хүснэгтэд тусгасан үйл ажиллагааг баяжуулан орон нутаг, сургуулийн онцлог, суралцагчдын хэрэгцээ шаардлагад тохируулан төлөвлөж, бүтээлчээр ашиглана уу.


Сэдэв 1. Машины хөдөлгөөнт загвар хийж турших

Зорилго: Суралцагчид дахин ашиглах материал (цаасан хайрцаг, хуванцар таглаа, соруул) /STEM, STEAM эд ангиудыг ашиглан 4 дугуйт хөдөлгөөнт машин зохион бүтээх, машинаар тоглонгоо налуу зам дээр туршин, дугуй гацах, эргэхгүй байгаа алдааг илрүүлэн дахин сайжруулж, бүтээлээ танилцуулна.

Суралцахуйн үр дүн : БШ(1.3а), ДУД(1.2б, 1.2м), МАТ(1.2а, 1.4а), МХ(1.1б, 1.1в), ЭМ(1.3а), НУ(1.1л).

Хэрэглэгдэхүүн: Дахин ашиглах материал (жижиг цаасан хайрцаг, ундааны хуванцар таглаа 4ш, соруул 2ш, / модон саваа 2ш, скоч, цавуу, аюулгүй хайч), STEM, STEAM хэрэглэгдэхүүний багц, туршилтын налуу хавтан, метр

Хэрэгжүүлэх жишиг үйл ажиллагаа	Чиглүүлэх асуулт
Багш суралцагчдад 2 өөр машиныг харуулна: Нэг нь дугуй нь эргэхгүй гацдаг, нөгөө нь налуу замаар амархан хөдөлдөг. - Суралцагчид хоёр машины ялгааг ажиглаж, дугуй яагаад эргэдэг, яагаад гацдаг талаар асуудал дэвшүүлэн ярилцана. - Хэрэглэгдэхүүний хайрцгаас дахин ашиглах материал (цаасан хайрцаг, таглаа, соруул) /STEM, STEAM-ийн эд ангиудыг гаргана.	- Энэ хоёр машины дугуй юугаараа өөр харагдаж байна вэ? - Машины дугуйг өнхрүүлэхийн тулд яах ёстой вэ? - Цаасан хайрцаг, хуванцар таглаагаар яаж машин хийх вэ?
- Суралцагчид 4 хүнтэй багт хуваагдаж, ямар материалаар машин хийхээ ярилцана (Дахин ашиглах материал эсвэл STEAM кит). - Баг бүр ажлын хуудсан дээрээ зохион бүтээх машины загварын тойм зургаа зурна. - Багийн гишүүд үүргээ хуваарилна: Их бие бүтээгч, Дугуй тогтоогч, Чимэглэгч, Эмхлэгч найз г.м.	- Дугуйг ямар материалаар хийвэл сайн өнхрөх вэ? - Тэнхлэг (саваа)-ийг соруулны дундуур хийвэл чөлөөтэй эргэж чадах уу? - Хэн юуг хариуцаж, ямар үүрэгтэй оролцох вэ?

Судлах, турших, бүтээх Багш багаж хэрэгслээ ашиглах, аюулгүй ажиллах зааврыг танилцуулна. - Аюулгүй ажиллагааны дэг мөрдөнө (хайч, цавууг зааврын дагуу хэрэглэх, таглааг аманд хийхгүй байх). *А хувилбар (дахин ашиглах материалаар)* - Суралцагчид цаасан хайрцаг дээр соруулаа нааж, соруул дундуур модон саваа (тэнхлэг) сүвлэн, савааны хоёр үзүүрт хуванцар таглааг бэхэлж 4 дугуйт машин бүтээнэ. - Ширээн дээр машинаа түлхэж, дугуй нь эргэж байгаа эсэхийг туршина. *Б хувилбар (STEAM, STEM хэрэглэгдэхүүнээр)* - Суралцагчид өгөгдсөн дарааллын дагуу машинаа угсарна.  (Mon STEAM-ийн багц хэрэглэгдэхүүнийг ашиглан төлөвлөв.)	- Машиныг угсрахад юуг анхаарах вэ? - Машиныг ямар дарааллаар угсрах вэ? *А хувилбар* - Тэнхлэг (саваа) соруул дотроо чөлөөтэй эргэж байна уу? - Дугуйг яаж тогтоовол салахгүй, сайн эргэх вэ? - Хайч, цавуугаа цэвэрхэн, аюулгүй ашиглаж байна уу? *Б Хувилбар* - Тулгуур дээрх түгжээтэй талыг сайтар ажиглаарай. - Моторыг аль боолтоор холбох вэ? - Яагаад дугуй эргэхгүй байна вэ? - Тархи, удирдлага хоёр хоорондоо зөв холбогдсон эсэхийг шалгаарай. - Зөв араануудыг сонгож ашигласан эсэхээ шалгаарай. - Их бие сул байгаа шалтгааныг олоорой.
- Зохион бүтээсэн машинаа ангид бэлтгэсэн налуу хавтан/зам дээр өнхрүүлэн туршина. - Эхний туршилтаар дугуй гацах, машин хазайх, эсвэл дугуй мултрах үед алдааг багаараа хэлэлцэнэ. - Алдааг засах: соруулын нүхийг томруулах, тэнхлэгийн бэхэлгээг чангалах, машины их биеийг жижиг болгох, тохируулах замаар засан сайжруулна (дахин оролдох).	- Налуу замаар машины дугуй эргэхэд ямар саатал гарсан бэ? - Алдаагаа засахын тулд аль хэсгийг өөрчлөх шаардлагатай вэ? - Сайжруулсны дараа машин хэр хол явж байна вэ?

Баг бүр засан сайжруулсан машинаа “Машины уралдаан”-д сорьж, ангийнхандаа танилцуулна. - Суралцагч бүр анх ямар алдаа гарсан, түүнийг яаж засснаа 3-4 бүтэн өгүүлбэрээр тайлбарлан ярина. - Багаж, цавуу, ашигласан материалаа ангилан хураана.	- Алдаагаа зассаны дараа машин чинь хэр хол өнхөрсөн бэ? - Багаараа машин зохион бүтээхэд юу хамгийн сонирхолтой байсан бэ?

Багшийн анхаарах зүйл:

- Бүтээлч үйл ажиллагааг сургуулийн бага ангийн багш нар болон Физик, Дүрслэх урлаг, дизайн технологийн багш нарын дэмжлэг, хамтын оролцоотой зохион байгуулах;
- Машин бүтээхэд ашигласан материалууд нь эрүүл ахуйн шаардлага хангасан байх;
- Дээрх бүтээлч үйл ажиллагааны машинаа угсрах хэсгийг танхимын үйл ажиллагаагаар, машинаа турших, уралдуулах хэсгийг танхимын бус үйл ажиллагаа (сургуулийн коридор, сургуулийн гадна талбайд)-аар нийт 35+35 минутын хугацаанд хэрэгжүүлэх;
- Суралцагчийн онцлогийг харгалзан (машины их биеийг багш урьдчилан бэлтгэсэн байна) зөвхөн угсралт хийж чимэглэх, мөн дугуй болон тэнхлэгийг угсрах зэргээр энгийнчлэх;
- STEAM, STEM багц хэрэглэгдэхүүнтэй сургуулиуд байгаа нөөцдөө тулгуурлан Б хувилбарыг сонгон хэрэгжүүлэх боломжтой.

Сэдэв 2. Хөгжимт хөдөлгөөн

Зорилго: Хөгжмийн аялгуу, хэмнэлийг мэдэрч, түүнийг дасгал хөдөлгөөнтэй хослуулан бүтээлчээр илэрхийлнэ. Мөн бусдын хөдөлгөөнийг ажиглах, хөгжмийн хэмнэлд тааруулан хөдөлгөөн гүйцэтгэснээр нийгэм-сэтгэл хөдлөлийн чадамжийг хөгжүүлнэ.

Суралцахуйн үр дүн: Хөг (1.1а, 1.2а, 1.3а), БТ (1.1а, 1.5б)

Хэрэглэгдэхүүн: Зөөврийн чанга яригч, урьдчилан сонгосон 3-4 төрлийн хөгжмийн ая (хурдан хэмнэлтэй; удаан хэмнэлтэй гэх мэт)

Санал болгох уран бүтээл:

"Алтан дөлт багваахай" Шүлэг: Ш.Бадарч, Ая: С.Батболд

"Хичээлийн завсарлагааны дуут бүжиг" Ая: С.Батболд, Шүлэг: Л.Соронзонболд

Санал болгох видео:

https://www.youtube.com/watch?v=ui7nQ6b4-TE

https://www.youtube.com/watch?v=BaMx4tvp6uU&list=RDBaMx4tvp6uU&start_radio=1

https://www.youtube.com/watch?v=935UBEm0gg0&list=RDBaMx4tvp6uU&index=16

Хэрэгжүүлэх жишиг үйл ажиллагаа	Чиглүүлэх асуулт
- Суралцагчдыг задгай, аюулгүй талбайд тойрог болгон зогсооно. - Урьдчилан бэлтгэсэн хөгжмийн хэмнэлийг (хурдан, удаан) сонсгоно. - Хөгжмийн өнгө аясыг тодорхойлно. - Хөгжмийн аялгуунд ямар хөдөлгөөн хийж болохыг төсөөлөн бодуулна.	- Хөгжмийн өнгө аяс нь ямар байсан вэ? (хурдан, удаан) - Хөгжмийн хэмнэлд ямар хөдөлгөөн хийж болох вэ?
- Багш гар, хөл, их биеийн үндсэн хөдөлгөөнийг хослуулан хийж харуулна. - Хурдан болон удаан хэмнэлтэй хөгжмийн аянд дасгал, хөдөлгөөнөө хослуулан гүйцэтгэнэ.	- Хурдан хэмнэлтэй хөгжим сонсвол ямар хөдөлгөөн хийж болох вэ? - Удаан хэмнэлтэй хөгжимд ямар хөдөлгөөн хийвэл тохиромжтой?

- Бичлэгийг бүтнээр нь үзэж, аяны хэмнэлийг мэдрүүлж, хөдөлгөөнийг ажиглуулна.
(Алтан дөлт багваахай хөгжимт хөдөлгөөн)
- Хөдөлгөөний үйлдлийг зааврын дагуу дуурайлган давтуулах
  - Аяны эхлэл хэсэгт байрандаа хэмнэлтэй алхах, гараа ташаандаа авч баруун, зүүн тийш хөдлөх
  - Гар ба хөлийн хослол — Гараа дээш, хажуу тийш өргөх, алгаа эргүүлэх хөдөлгөөнийг аяны хэмнэлд тааруулах
  - Үсрэлт ба тэнцвэр — Хоёр хөл дээр зөөлөн үсрэх, тэнцвэрээ хадгалах
- Хөгжимгүйгээр хөдөлгөөнийг тоогоор хийх, дараалал бүрээр давтана.
- Хөгжмийн аялгуунд сурсан хөдөлгөөнөө аятайгаа тохируулан хийнэ.
	- Анхааралтай ажиглаарай
	- Дагаад хийгээрэй
	- Ямар хөдөлгөөнийг хийхэд амархан/хэцүү байсан вэ?

- Суралцагчдыг багт хуваах, өөрийн хамгийн сайн хийж сурсан хөдөлгөөнөө найзууддаа хуваалцана. - Хөдөлгөөний алдаа гаргасан эсэхийг ярилцах, засаж гүйцэтгэнэ.	- Найзын хийсэн хөдөлгөөн хэмнэлдээ таарч байна уу? - Ямар хөдөлгөөнийг засаж сайжруулсан вэ? - Хөгжмийн аялгууд хөдөлгөөнийг хослуулан хийж чадаж байна уу?
- Ангиараа хамтран сурсан хөгжимт хөдөлгөөнөө гүйцэтгэнэ. - Хөгжмийн аялгуунд хөдөлгөөн хийхэд ямар сэтгэгдэл төрж байгааг ярилцана.	- Хөгжим болон хөдөлгөөнийг хослуулж гүйцэтгэхэд ямар мэдрэмж төрсөн вэ?

Багшийн анхаарах зүйл:

- Бүтээлч үйл ажиллагааг сургуулийн бага ангийн багш нар болон биеийн тамир, хөгжмийн багш нарын дэмжлэг, хамтын оролцоотой зохион байгуулах;
- Анги нийтээрээ эсвэл жижиг багт хувааж, танхим болон танхимын бус (сургуулийн заал, урлаг заал, анги танхим, гадна талбай) үйл ажиллагаагаар хэрэгжүүлэх;
- Хөгжмийн аялгуу нь тодорхой хэмнэлтэй байхаар сонгох;
- Хөгжмийн дууны түвшнийг хүүхдийн сонсголд тохиромжтой хэмжээнд байлгах;
- Хөгжмийн аяны хэсэг бүрийг 1–2 минут тоглуулж, хүүхдийн анхаарлыг татах;
- Аюулгүй, тэгш гадаргуутай, зай талбайд хөдөлгөөнийг хийлгэх;
- Биеийн хөдөлгөөнд саад учруулахгүй байхаар хувцаслах;
- Хүүхэд бүрийн хөдөлгөөний эвсэл ялгаатай тул "буруу хийлээ" гэж шүүмжлэхгүй, идэвхтэй оролцоог урамшуулах.

Суралцагчийн оролцоо ба ахицыг ажиглах хуудас

Анги: ..... Багш: ..... Огноо: .....

Хэрэглэх заавар: Багш суралцагчдын хөгжмийн хэмнэлийг мэдэрч буй байдал, хөдөлгөөнийг гүйцэтгэж буй байдлыг хичээлийн явцад ажиглаж хүснэгтэд тэмдэглэнэ.

Тэмдэглэгээ: Хөдөлгөөнийг гүйцэтгэж буй байдал:

✓ - Бие даан хийж байна.
Д - Дэмжлэгтэй хийж байна.
↑ -Өмнөх оролдлогоос ахисан.

Хөгжмийн хэмнэлийг мэдэрч буй байдал:

✓ -Хөгжмийн хэмнэлийг ялган сонсож байна.

Х -Хөгжмийн хэмнэлийг сул ялган сонсож байна.

Жишээ: ✓ Д ↑ Х эдгээр тэмдэглэгээг суралцагч бүрийн хичээлийн явцад ажиглаж хоосон нүдэнд тэмдэглэнэ.

№	Суралцагчийн нэр	Хөгжмийн хэмнэлд тохируулан хөдөлгөөн гүйцэтгэж буй байдал	Хөгжмийн хэмнэлийг мэдэрч буй байдал	Сайжруулах зүйл
1				
2				

Сэдэв 3. Хамтдаа бүтээсэн зураг

Зорилго: Найзынхаа эхлүүлсэн зурагт өөрийн төсөөлөл, санааг нэмж дүрслэх, санаагаа тайлбарлах, бусдыг сонсон ээлжээр оролцож хамтын бүтээл хийх замаар суралцагчийн бүтээлчээр сэтгэх, харилцах, хамтран ажиллах чадамжийг хөгжүүлнэ.

Суралцахуйн үр дүн: ДУД(1.1а, 1.2е), МХ(1.1б, 1.1в).

Хэрэглэгдэхүүн: Ханын том цаас, өнгийн харандаа

Хэрэгжүүлэх жишиг үйл ажиллагаа	Чиглүүлэх асуулт
- Ангийн багш том цаасан дээр энгийн дүрс эсвэл зурж эхлүүлнэ. - Бусад суралцагч юутай төстэй, юу нэмж болох талаар шинэ санаа гарган үргэлжлүүлэн зурна.	- Ямар зураг, дүрслэлээр эхэлж болох вэ? - Энэ дүрс юутай төстэй байна вэ? - Хэрхэн яаж үргэлжлүүлж зурах вэ?
- Суралцагч бүр зурахдаа ээлж дарааллын дагуу зурна. Найзынхаа зурсан зургийг арилгахгүй, нэмэх санаагаа зургаар илэрхийлэх, ээлжээ хүлээх гэсэн дүрмийг ярилцан тохирно.	- Хэн эхэлж, хэн дараа нь зурах вэ? - Найзынхаа зурсан санааг яаж үргэлжлүүлэх вэ?
- Ханын цаас дээр суралцагч бүр зургийг нэмж баяжуулан зурна. - Өмнөх суралцагчийн зурсан зурагтай холбон амьтан, ургамал, орчин, зам, байшин, үйл явдлыг зурна.	- Найзынхаа зурагт юу нэмж болох вэ? - Чиний нэмж зурсан хэсэг бусадтайгаа хэрхэн холбогдох вэ?
- Хамтын зургаа харж, юуг дүрсэлсэн байгаа талаар ярилцана. - Бүтээсэн зургаа ойлгомжтой болгоход хэрэгтэй жижиг хэсгийг нэмж зурна. - Бусдын зурсан хэсгийг өөрчлөх бол заавал зөвшөөрөл авахыг сануулна.	- Бидний зурсан зурагт юу болж байна вэ? - Зургийг ойлгомжтой болгохын тулд юу нэмж зурах вэ?
- Бүтээсэн зурагтаа нэр өгч, суралцагч бүр нэг өгүүлбэр нэмэн богино түүхийг бүтээнэ. - Суралцагчид бүтээсэн зургийнхаа өөрийн хэсгийг зааж тайлбарлаж болно.	- Эхлээд юу болсон бэ? - Дараа нь юу болсон бэ? - Найзын чинь нэмсэн хэсэг ямар шинэ санаа төрүүлсэн бэ?

Багшийн анхаарах зүйл:

- Бүтээлч үйл ажиллагааг сургуулийн бага ангийн багш нар болон нийгмийн ажилтан, сэтгэл зүйч нарын дэмжлэг, хамтын оролцоотой зохион байгуулах;
- Бүтээлч үйл ажиллагааг танхим болон танхимын бус (ангийн булан, сургуулийн коридор, гадна талбай) хэлбэрийн аль нэгийг сонгож, 3–4 баг болж хамтын бүтээл хийх;
- Зургийн сэдвийг суралцагчидтай хамтран сонгож, бэлэн загвар тулгахгүйгээр өөрийн төсөөлөл, санаагаа илэрхийлэх боломж олгох;
- Хүүхэд бүр зурагт өөрийн хэсгийг нэмэх боломжтой байхаар цаасны зай, зурах ээлжийг тохируулах;
- Найзынхаа зурсан хэсгийг хүндэтгэх, өөрчлөхдөө зөвшөөрөл авах, санал зөрвөл эелдгээр ярилцаж шийдэхэд чиглүүлэх;
- Хүүхдүүдийн чадварыг харьцуулахгүйгээр шинэ санаа, оролдлого, хамтын оролцоог урамшуулах;
- Дэмжлэг хэрэгтэй суралцагчид өнгө, дүрс сонгох, санаагаа хэлэх, зааж үзүүлэх зэрэг өөрт тохирсон аргаар оролцох боломж бүрдүүлэх;
- Бүтээлээ танилцуулахдаа хүүхэд бүр өөрийн нэмсэн хэсгийг зааж, богино өгүүлбэрээр тайлбарлахыг дэмжих;
- Хэрэглэгдэхүүнээ хуваалцаж, үйл ажиллагааны дараа хамтдаа хураах дадлыг хэвшүүлэх.

Суралцагчийн оролцоо ба ахицыг ажиглах хуудас

Анги: ..... Багш: ..... Огноо: .....

Хэрэглэх заавар: Багш зураг бүтээх болон танилцуулах явцад ажиглаж, доорх үзүүлэлтээр тэмдэглэнэ.

Тэмдэглэгээ:

✓ — Бие даан хийсэн.

Д — Чиглүүлэг, дэмжлэгтэй хийсэн.

↑ — Өмнөх оролдлогоос ахисан нь ажиглагдсан бол үндсэн тэмдэглэгээний хажууд нэмнэ.

Жишээ: ✓ Д ↑ эдгээр тэмдэглэгээг суралцагч бүрийн хичээлийн явцад ажиглаж хоосон нүдэнд тэмдэглэнэ.

№	Суралцагчийн нэр	Өөрийн санаагаар зурагт хэсэг нэмж, түүнийгээ тайлбарлах	Бусдыг сонсож, ээлжээ хүлээн хамтран оролцох
1			
2			

Сэдэв 4. Бид нэг ангийнхан

Зорилго: Суралцагчид өөрийн болон найз нөхдийнхөө ижил, ялгаатай талыг танин мэдэж, хүн бүр анги хамт олондоо хувь нэмэртэй болохыг ойлгон, бусдыг сонсож, хамтран ажиллах замаар "Нэг ангийнхан мод" бүтээнэ.
Суралцахуйн үр дүн: НУ (1.1б), БШ (1.1а, 1.4в), (ДУД-1.2к):
Хэрэглэгдэхүүн: А3 картон (Баг тус бүрт 1 ширхэг), олон өнгийн усан будаг, гуашь, бийр, гуашийн таваг, усны сав, нойтон болон хуурай салфетка, алчуур, сургуулийн ойр орчмоос цуглуулсан унасан, хатсан навчнууд, өнгийн харандаа, фломастер, цавуу хайч, скоч, багийн тэмдэг (Ахлагч, Будагч, Наагч, Эмхэтгэгч)

Хэрэгжүүлэх жишиг үйл ажиллагаа	Чиглүүлэх асуулт
1. Багш сурагчдыг сургуулийн цэцэрлэгт хүрээлэнд эсвэл цонхоор орчноо ажиглах боломжоор хангана. 2. Модны навчны өнгө, хэлбэр, хэмжээг ажиглана. 3. Мод ба Анги хамт олны зүйрлэл: - "Модонд ганцхан навч байвал ямар харагдах вэ?" - "Модны навч бүр бүгд ижилхэн үү?" - Навч бүр өөр өнгө, хэлбэртэй ч нэг модыг үзэсгэлэнтэй, бүтэн болгодог шиг манай ангийн хүүхэд бүр өөр өөрийн онцлогтой, сонирхолтой.	- "Ямар өнгийн навч хамгийн их харагдаж байна вэ? Навчнууд бүгд адилхан уу?" - "Энэ моддыг манай анги гэж бодвол, үндэс, их бие, мөчир, навч нь юуг илэрхийлэх вэ?"
1. Багш сурагчдыг 4-5 хүнтэй багуудад хуваана. 2. Багийн үүрэг хуваарилалт: Баг бүр дараах үүргийг хоорондоо зөвшилцөн хуваарилна: Их бие зураач: Модны үндэс, их бие, мөчрийг зурах/будах. Навч бүтээгчид: Гарын хээгээ даран, өнгө сонгон будах. Байгалийн навчийг наагч: Унасан навчийг цавуудаж наах. Эмх цэгц хариуцагч: Будаг, ус, цавууны аюулгүй байдлыг хангах, бохирдохоос сэргийлэх. 3. Багаараа ажиллах "Элдэг харилцааны 3 дүрэм"-ийг тохиролцоно: А. Бусдадаа боломж олгоно (Дарааллаа хүлээх). Б. Бусдын хөдөлмөрийг хүндэтгэнэ (Бусдын зурсныг сараачихгүй). В. Багаар эелдэг ярилцана (Намуун дуугаар ярих).	- "Манай багийн бүтээлд ямар ямар хэсгүүд хэрэгтэй вэ? Хэн ямар ажлыг хариуцах вэ?" - "Бүгдээрээ тэгш оролцохын тулд бид бие биедээ хэрхэн туслах вэ?"
Их бие ба мөчир бий болгох: А3 картон цаасан дээр модны их биеийг зурж будна. *Их бие нь "Манай анги, манай сургууль" гэсэн суурийг илэрхийлнэ.*	- "Бидний дарснаар чиний гарын хээ бусад хүүхдийнхээс юугаараа ялгаатай, юугаараа ижилхэн харагдаж байна вэ?"

<table>
<tr>
<td>Гарын хээгээр навч дарах: Сурагч бүр өөрийн дуртай усан будгийг сонгон гараа будаж, модны мөчир дээр гарын хээгээ дарна.
Гарын хээний хажууд эсвэл дотор сурагч өөрийн нэр, эсвэл өөрийгөө илэрхийлэх бяцхан тэмдэглэгээ (бэлэг тэмдэг, эможи, зураг)-г зурна.
Байгалийн цуглуулсан хэсэгт эсвэл баяжуулна.
материалтай интеграци хийх: Ажиглаж бодит унасан навчнуудыг модны доод мөчирт цавуудан нааж, бүтээлийг
Аюулгүй гараар байх, нойтон цэвэрлэх дэг


байдал ба ариун цэвэр: Будагтай хувцсандаа болон бусдадаа хүрэхгүй салфеткаар гараа цаг тухайд нь сахиулна.</td>
<td>- - "Ангиараа нэг модонд гарын хээгээ дарахад ямар мэдрэмж төрж байна вэ?"</td>
</tr>
<tr>
<td>1. Баг бүр бүтээлээ нэгтгэн харна. Мод нь бүтэн харагдаж байгаа эсэх, хоосон зай байгаа эсэхийг ярилцана.
2. Багийн бүтээлдээ нэр өгнө. (Жишээ нь: "Эвтэй 1а ангийн мод", "Нөхөрсөг нандин мод", "Үзэсгэлэнт 1-р анги" гэх мэт).
3. Модны үндэс хэсэгт "Бидний ажигласан намрын өнгө" болон багийн хүүхдүүдийн дуртай зүйлсийг зургаар нэмж баяжуулна.</td>
<td>- "Манай багийн модонд дутуу зүйл байна уу? Бид модоо ямар нэрээр нэрлэвэл биднийг хамгийн сайн илэрхийлэх вэ?"
- "Манай бүтээлээс бидний эвтэй суралцаж байгаа нь харагдаж байна уу?"</td>
</tr>
<tr>
<td>1. Баг бүр хийсэн "Нэг ангийнхан мод"-оо ангийнхандаа үзүүлж, танилцуулга хийнэ.
2. Танилцуулгын заавар:
- Бүтээлийн нэр.
- "Манай модонд хэний ямар онцлогтой навчнууд (гарын хээ) байгаа вэ?"
- "Багаараа ажиллахад бидэнд юу хамгийн сайхан байсан бэ?"
3. Багшийн нэгтгэн дүгнэлт:
- Багш сурагчдын бүтээлийг ангийн хананд нэгтгэн байрлуулж "МАНАЙ АНГИЙН ОЙ" үзэсгэлэн гаргана.</td>
<td>- "Ангийнхантайгаа хамтарч бүтээл хийхэд чамд юу хамгийн сонирхолтой санагдсан бэ?"
- "Найзынхаа хийсэн зүйлээс чамд аль нь хамгийн их таалагдсан бэ?"</td>
</tr>
</table>

- "Хүүхдүүд ээ, мод бүр өөр өөр өнгийн навчтай боловч нийлээд үзэсгэлэнтэй ой болдог шиг, бид бүгдээрээ өөр өөр авьяас сонирхолтой ч нийлээд нэгэн сайхан, эвтэй анги хамт олон болж байгаа юм шүү."	- "Бид цаашдаа ангиараа эвтэй байхын тулд юу хийх ёстой вэ?"

Багшийн анхаарах зүйл:

- Багаар (4-5 хүүхдэд нэг баг) ажиллахаар дугуй эсвэл дөрвөлжин хэлбэрээр байрлуулна.
- Хүүхэд сургуулийн орчинд орсноор "Би" гэдэг ойлголтоос "Бид" буюу анги хамт олон гэсэн нийгмийн бүлгийн гишүүн болох анхны шилжилтээ хийдэг. "Нэг ангийнхан мод" сэдэв нь сурагч бүрийн давуу тал "Анги хамт олон" дээр нэгдэн хөгжих боломжтойг биетээр ойлгоход чиглэнэ.
- Бусдын орон зай, ялгаатай байдлыг хүндэтгэх, ангийн дүрэм журмыг сахих, багийн үүрэг хуваарилалтыг ухамсарлах, шийдвэр гаргахад тэгш оролцох зэргээр шүүн тунгаах, харилцах хамтрах, бүтээлчээр сэтгэх ерөнхий чадамжийг хөгжүүлнэ.
- Тэгш оролцоо: Ичимхий, зожиг эсвэл тусгай хэрэгцээтэй сурагчийг багийн ажилд орхигдуулахгүй байхад анхаарч, тэдэнд тохирсон дэмжлэг болон үүргийг (наагч, будагч г.м) онооно.
- Байгаль дэлхийгээ хайрлах: Амьд модны навчийг тасдаж авахгүй, зөвхөн газар унасан, хатсан навчийг цуглуулан ашиглах байгаль хамгааллын дадал төлөвшүүлнэ.
- Хандлага: Будаг асгах, цавуу нялах зэрэг алдаа гарсан үед сурагчийг зэмлэхгүйгээр, хамтран цэвэрлэх, бие биедээ туслах боломж олгоно.

Суралцагчийн оролцоо ба ахицыг ажиглах хуудас

Сурагчийн нэр	Багаар ажиллахдаа бусдыг хүндэтгэсэн эсэх	Үүргээ хариуцлагатай биелүүлсэн эсэх	Гарын хээ, байгалийн материал ашиглаж бүтээл хийсэн эсэх
Жишээ: Болд	Бусдадаа зай тавьж, дарааллаа хүлээсэн.	Будгийг найздаа дөхүүлж өгсөн.	Модны их биеийг зурахад идэвхтэй оролцсон.
Жишээ: Туяа	Санаагаа эелдгээр хэлсэн.	Бохирдсон хэсгийг арчихад тусалсан.	Гарын хээгээ маш цэвэрхэн дарсан.

Сэдэв 5. Музейн аялал

Зорилго: Суралцагчид орон нутгийнхаа музейн үзмэрүүдийг (ахуйн хэрэгсэл, байгалийн ховор зүйлс, түүхийн дурсгал) багшийн чиглүүлэг асуултын дагуу биечлэн ажиглаж, төрөлх нутгийнхаа онцлог, соёл, бахархлыг танин мэднэ.

Суралцахуйн үр дүн: НУ (1.1е, 1.1ж, 1.1з, 1.1и), МХ (1.1в), ДУД (1.3а, 1.3б),

Хэрэглэгдэхүүн: Ажиглалтын хуудас, стикер

Хэрэгжүүлэх жишиг үйл ажиллагаа	Чиглүүлэх асуулт
- Музейн үүдний хэсэгт багш сурагчдын сонирхлыг татаж, ажиглалтын аяллын сэдэв болон асуултыг танилцуулна. - Сурагчид асуултад хариулж, музейн танхим руу үзмэрийг сонирхон ажиглахаар бэлтгэнэ. - Музейд соёлтой оролцох дүрмийг сануулна.	- "Хүүхдүүд ээ, бидний амьдардаг орон нутгийг (сум) юу гэж нэрлэдэг билээ?" - Манай орон нутагт ямар уул, ус, сонирхолтой эртний зүйлс байдгийг энэ музейгээс хамтдаа харж чадах болов уу?"
- Багш сурагч бүрд орон нутгийн музейн үзмэрт тааруулсан ажиглалтын хуудсыг өгч, ажиглах дарааллаа сонгон төлөвлөнө. - Сурагч бүр ажиглалтын хуудсыг авч, ажиглах үзмэрийн зургуудтай танилцана. - Ямар үзмэрийг эхэлж олохоо төлөвлөнө. Ажиглалтын хуудас дээрх 4 зураг (Орон нутгийн музейн үзмэрүүд): 1. Хуучны ахуйн хэрэгсэл (Авдар, домбо, сүүний шанага г.м) 2. Байгалийн сонин биет (Гоё чулуу, амьтны дүрс/чихмэл) 3. Монгол соёлын үзмэр (Морин хуур, эмээл) 4. Сумын бахархал (Түүхэн зураг, Соёмбо эсвэл Далбаа)	- "Ажиглалтын хуудас дээрх 4 зургийг сайн хараарай. Эндээс аль үзмэрийг хамгийн эхэнд хайж олохыг хүсэж байна вэ?" - "Стикерээ бүтэн наахын тулд дараа нь ямар үзмэрийг хайхаар төлөвлөж байна вэ?"
Орон нутгийн музейн үзмэрийг ажиглах: - Сурагч бүр музейн танхимаар аялж, үзмэртэй танилцаж, ажиглалтын хуудас дахь зургуудаа үзмэрээс олно. - Олсон үзмэрийн зураг бүрд стикер наана. - *Ажиглалт 1* (Хуучны ахуйн хэрэгсэл): Уг үзмэрийг заан багшид харуулж, 1 дэх стикерээ наана. - *Ажиглалт 2* (Байгалийн сонин биет): Байгалийн үзмэрийг олж заагаад, 2 дахь стикерээ наана. - *Ажиглалт 3* (Монгол ахуй, соёлын үзмэр):Үзмэрийг зааж, 3 дахь стикерээ наана. - *Ажиглалт 4* (Орон нутгийн бахархал): олж 4 дэх стикерээ наана.	- "Өвөө, эмээгийнх нь хэрэглэж байсан ямар модон эсвэл төмөр эд зүйл байна вэ? Энэ зүйлийг юунд хэрэглэдэг байсан бэ?" - "Манай нутгийн уул, хөндийгөөс олдсон ямар гоё чулуу эсвэл амьтны дүрс байна вэ?" - "Энд байгаа морин хуур, эмээл эсвэл монгол гэрийн хэсгийг олоод заагаарай." - "Манай орон нутгийн түүхэн зураг эсвэл улсын Төрийн далбаа, Соёмбо хаана байна вэ?"

- Багш сурагч бүрийн ажиглалтын хуудас дээрх 4 стикерийг шалгаж, дутуу ажигласан үзмэр байвал хамтдаа нөхөн ажиглаж баяжуулна. - Сурагчид өөрийн ажиглалтын хуудасны стикерүүдээ шалгана. - Ажиглалтаа баяжуулж, өөр ямар сонирхолтой үзмэр байгааг нэмж ажиглана.	- "Бүгдээрээ 4 үзмэрээ бүрэн олж стикерээ нааж чадсан уу?" - "Олсон үзмэрүүдээс өөр сонирхолтой ямар зүйл энэ музейд харагдсан бэ?"
- Музейн сургалтын хэсэгт тойрч зогсон, ажиглалтын туршлагаа хуваалцана. - Сурагчид стикерээ наасан ажиглалтын хуудсаа барин сэтгэгдлээ аман хэлбэрээр хуваалцана. - Багшийн дүгнэлт: "Өнөөдөр бид орон нутгийнхаа музейгээр аялж, нутгийнхаа соёл, бахархлыг танин мэдэж авлаа. Хүүхэд бүр нутаг орноо хайрладаг сайн хүүхэд болоорой."	- "Манай орон нутгийн музейн үзмэрүүдээс чамд хамгийн их таалагдсан нь ямар үзмэр байсан бэ?" - "Төрөлх нутгаа хэрхэн, хайрлан хамгаалах вэ?"

Багшийн анхаарах зүйл:

- Танхимын бус үйл ажиллагааг зохион байгуулахдаа эцэг эх, сургалтын менежер, нийгмийн ажилтны дэмжлэг, хамтын оролцоотой суралцагчдын аюулгүй байдалд анхаарах;
- Музейн орчинд сурагчдыг гүйхгүй, үзмэрийн шил болон биетэд хүрэхгүй байх, чимээ шуугиан гаргахгүй соёлтой ажиглалт хийх дүрмийг эхэнд нь ойлгуулж сануулах;
- Тусгай дэмжлэг шаардлагатай суралцагчийг орхигдуулахгүйгээр хажууд нь очиж чиглүүлэн, стикерээ өөрөө наахад нь туслах;
- Сумын эсвэл орон нутгийн музейн үзмэрийн нэр төрөл, тоо хэмжээнд тохируулан ажиглалтын хуудасны 4 зургийг урьдчилан бэлтгэх;
- Суралцагчдад зөвхөн үзмэр харуулахаас гадна өвөг дээдсийн өв соёл, нутаг орныхоо байгалийг хайрлах, бахархах эерэг хандлагыг багш аман тайлбараар чиглүүлж өгөх.

Суралцагчийн оролцоо ба ахицыг ажиглах хуудас

Үнэлгээний шалгуур	Дэмжлэг шаардлагатай	Хөгжиж байгаа	Амжилттай
Ажиглах, Заан харуулах	Үзмэрийг багшийн зааврааар зааж харуулахад анхаарал нь сарниж байсан.	Багшийн тусламжтайгаар музейн үзмэрүүдийг заан харуулж стикерээ наасан.	Чиглүүлэг асуултыг сонсоод үзмэрийг хурдан олон зааж, бие даан ажигласан.
Асуултад хариулах (Аман яриа)	Багшийн асуултад хариулахгүй, дуугүй байсан.	Чиглүүлэг асуултад товч хариулсан.	Асуултад өөрийн үгээр сонирхолтойгоор хариулж, сэтгэгдлээ ярьсан.

Сэдэв 6. Бидний дэг

Зорилго: Танхимд болон танхимын бус орчинд суралцах, харилцах, бүтээх, цахим хэрэгслийг зохистой хэрэглэх дэгийг зурагт хэлбэрээр хамтран боловсруулж, жишээ нөхцөлд хэрэглэх

Суралцахуйн үр дүн: ЭМ(1.7а), НУ(1.1л), МХ(1.1в)

Хэрэглэгдэхүүн: Том цаас, жижиг цаас, өнгийн харандаа, цавуу, өдөр тутмын нөхцөл харуулсан зурагт карт

Хэрэгжүүлэх жишиг үйл ажиллагаа	Чиглүүлэх асуулт
Багш суралцагчдад гурван өөр нөхцөл байдлыг харуулсан зурагт карт үзүүлнэ. Үүнд: - Танхимд хамтдаа зураг зурж, бүтээл хийж буй хүүхдүүд - Гадаа талбайд тоглож буй хүүхдүүд - Гэртээ утас, зурагт үзэж буй хүүхэд Сурагчид зурагт юу харагдаж байгааг өөрсдийн өдөр тутмын амьдрал, туршлагатай холбон ярилцана.	- Зураг дээр хүүхдүүд юу хийж байна вэ? - Та нар хамтдаа тоглох, зурах эсвэл дэлгэц үзэхдээ ямар дэгийг баримталдаг вэ? - Эдгээр зурагт тохируулан хамтдаа ямар дэг, дүрмийг зохиох вэ?
Баг бүрд өдөр тутам тохиолддог нэг нөхцөл байдлыг өгнө. 1-р баг: Найзыгаа ярьж байхад хэлэх зүйл гарвал яах вэ? 2-р баг: Нэг цавуу эсвэл хайчийг хоёр хүүхэд нэгэн зэрэг хэрэглэх болбол яах вэ? 3-р баг: Гадаа тоглож байхад багш цугларах дохио өгвөл яах вэ? 4-р баг: Дэлгэц үзэхээр тохирсон цаг дуусвал яах вэ? Суралцагч тухайн асуудлыг хэрхэн шийдвэрлэхээ ярилцана.	- Эдгээр нөхцөл байдал чамд тохиолдвол хамгийн түрүүнд ямар үйлдэл хийх вэ? - Найзтайгаа хэрхэн ойлголцох, ямар дэгийг баримтлах вэ?
Баг бүр хамтдаа сурах, гадаа тоглох, цахим хэрэгсэл ашиглах үед мөрдөх дэгээс нэгийг сонгон, хамтран зохионо. Баг бүр сонгосон нэг дэгийг дүрслэн зурагт хуудас бүтээнэ. Дэгийг бусдад ойлгомжтой байдлаар багшийн тусламжтайгаар 1-2 богино өгүүлбэрээр бичиж тэмдэглэнэ.	- Бид хамтдаа сурах, гадаа тоглох, цахим хэрэгсэл хэрэглэхдээ ямар дэг мөрдвөл хамгийн тохиромжтой вэ? - Эдгээр дэгийг бусад хүүхдүүдэд ойлгомжтой байхаар зургаар илэрхийлж болох уу? - Зурган дээр ямар тэмдэг, дүрслэл байвал болох вэ?

Багууд хийсэн зурагт дэгээ хоорондоо солилцож, бусад багийн зургийг ажиглан ямар дэг болохыг тааж тайлбарлана. Багш дараах нөхцөлүүдийг дэвшүүлж, тохирох зурагт дэгийг гаргаж ирнэ. - Харанхуй өрөөнд утас үзэх гэж байвал яах вэ? - Зураг зурахад будаг дундаа хэрэглэх болбол яах вэ? Зураг нь тодорхойгүй, ойлгомжгүй байвал хүүхдүүд хамтран зурж, засан сайжруулна.	- Багшийн хэлсэн эдгээр нөхцөлд аль зурагт дэг тус болох вэ? - Энэ зураг ямар үйлдэл хийхийг сануулж байна вэ? - Зурагт дэг нь ойлгомжгүй байвал юуг нь сайжруулах вэ?
Баг бүрийн урласан зурагт дэгүүдийг нэгтгэж "Бидний дэг" гэсэн бүтээлийг самбарт байрлуулна. Суралцагч бүр өөрийн заавал мөрдөх нэг дэгийг сонгон зааж тайлбарлана. Цахим хэрэгслийн аюулгүй хэрэглээний дэгийг гэр бүлийнхэнтэйгээ хамтран бүтээнэ.	- Бидний бүтээсэн энэ дэгүүдээс өнөөдрөөс эхлэн ямар дэгийг мөрдөж эхлэх вэ? - Цахим хэрэгслийн дэгийг гэрийнхэнтэйгээ хэрхэн хийх вэ?

Багшийн анхаарах зүйл:

- Хүүхдэд танил, нэг удаагийн тодорхой үйлдлээр шийдэх боломжтой энгийн нөхцөлийг сонгоно.
- Дэгийг бэлнээр хуулуулж цээжлүүлэхгүй, хүүхдийн саналд тулгуурлан богино өгүүлбэр, зурагт картаар боловсруулна.
- Цахим хэрэглээний хугацааг хүүхэд өөрөө дангаар шийдэх бус, эцэг эх, асран хамгаалагчтайгаа тохирдог болохыг ойлгуулах.
- Дэлгэцээс завсарлах үеийн хөдөлгөөн, тоглоом, зураг зурах, ном үзэх зэрэг сонголтыг хүүхдүүдээр гаргуулах.

Хамтран боловсруулах зурагт дэгийн жишээ

Үйл ажиллагааны чиглэл	Дэгүүд
Хамтдаа сурах, бүтээхдээ	1. Нэгнийгээ анхааралтай сонсож, ээлжээр ярья. 2. Сургалтын хэрэглэгдэхүүнийг заавал асууж аваад, ээлжлэн хэрэглээ. 3. Бүтээл хийж дууссаны дараа хэрэглэснээ хамтдаа цэвэрлэн хураая.
Гадаа ба танхимын бус орчинд	1. Багшийн заасан талбайд хамтдаа аюулгүй зорчъё. 2. Ургамал, цэцэг, жижиг амьтдыг гэмтээхгүйгээр хайрлан ажиглая. 3. Багшийн цуглах дохио өгөхөд тохирсон газартаа цуглая.

Цахим хэрэгсэл хэрэглэхдээ	1. Хэзээ эхлэх, хэдэн минут үзэхээ том хүнтэйгээ заавал тохиролцъё. 2. Дэлгэц үзэх хугацаа дууссан үед хичээлээ хийе 3. Дэлгэц үзэхдээ хол зайнаас үзье

Сэдэв 7. Миний бяцхан найз

Зорилго: Дахин ашиглах материал (цаасан аяга, даавуу, товч, цаасан таваг)-аар хүүхэлдэй урлан бүтээж, өөрийн бүтээсэн хүүхэлдэйн дүрд хувиран, сэтгэл хөдлөлөө нээлттэй илэрхийлэх, өөрийгөө танилцуулах.

Суралцахуйн үр дүн: ДУД (1.1а, 1.2б, 1.2л), МАТ (1.2а), МХ (1.1б, 1.3б)

Хэрэглэгдэхүүн:

- Цаасан аяга, цаасан таваг, хуванцар таглаанууд.
- Даавууны өөдөс, өнгөтэй утас, товчнууд, хатаасан навч.
- Бичгийн цаас, өнгийн цаас, балын ба өнгийн харандаа, фломастер.
- Модон богино савх, шингэн цавуу, аюулгүй дугуй үзүүртэй хайч.

Хэрэгжүүлэх жишиг үйл ажиллагаа	Чиглүүлэх асуулт (жишээ)
- Багш бэлэн цаасан аяган ба цаасан тавагтай хүүхэлдэйг харуулж, дуу хоолойгоо өөрчлөн сурагчидтай мэндчилж сонирхлыг татна. - Гарын доорх, дахин ашиглах материалын талаар богино ярилцлага хийнэ.	- Энэ хүүхэлдэйг юугаар хийсэн байна вэ? - Бид гэртээ болон ангид гардаг хаягдал цаас, аягаар шинэ тоглоом хийж чадах уу?
- Суралцагчид ямар хүүхэлдэй (охин, хүү, үлгэрийн баатар, амьтан) хийхээ сонгож, ажлын хуудас дээрх загвартаа анхны санаагаа тоймлон зурна.	- Чи өөрийнхөө бяцхан найзад ямар нэр өгөх вэ? - Найздаа ямар зан чанар, царай төрх гаргахыг хүсэж байна вэ?
Багш сурагчдад дараах аюулгүй ажиллагааны санамжийг танилцуулна: - Хайчийг бусдад өгөхдөө ишнээс нь барьж өгнө. - Цавууг аманд болон нүдэнд хүргэхгүй, зохистой хэмжээгээр хэрэглэнэ. Бусдын хийсэн хүүхэлдэйд зөвшөөрөлгүй хүрэхгүй, хүндэтгэлтэй хандана.	- Нүд, амыг нь ямар дүрсээр хайчилж наах вэ? - Үсийг нь ямар өнгийн утас эсвэл навчаар хийх вэ?

3 сонголтоор бүтээх боломж олгоно: - А .(Цаасан аяга): Аягыг уруу нь харуулж, дээр нь таглаа, товч, өнгөт цаасаар нүд, ам, чих, малгай наана. - Б. (Даавуу ба товч): Модон савханд даавуу, утас, товч наан хүүхэлдэй урлана. - В. (Цаасан таваг): Цаасан таваг дээр нүүрний хувирал будаж зуран, утас, навчаар үс хийнэ.Багш аюулгүй байдлын дэгийг сануулж, дэмжлэг үзүүлнэ.	- Цавууг хаана нь түрхвэл илүү цэвэрхэн наалдах вэ?
- 3 минутын "Хөгжөөнт хөдөлгөөн" чилээ гаргах дасгал хийнэ. - Хосоор ажиллах: Сурагч бүр бүтээсэн хүүхэлдэйгээ ширээний найздаа 1 минут танилцуулна.	- Миний хүүхэлдэйг ..... гэдэг. - Тэр .....-аар хийсэн урт гоё үстэй. - Найзын чинь хүүхэлдэй юугаараа онцлогтой байна вэ?
- Суралцагчид хосоор эсвэл 4 хүнтэй баг болж, хүүхэлдэйгээрээ харилцан ярьж, бяцхан жүжигчилсэн тоглолт хийнэ. - Ашигласан багаж, хэрэглэгдэхүүнээ хурааж, ширээгээ цэгцэлнэ.	- Хүүхэлдэй чинь найздаа юу гэж хэлж байна вэ? - Өнөөдөр ямар материал ашиглахад хамгийн сонирхолтой байсан бэ? - Хайч, цавуугаа хаана буцааж тавих вэ?

Багшийн анхаарах зүйл:

- Багш дээрх үйл ажиллагааг сургуулийн орчин, гарын доорх материал хэрэглэгдэхүүний сонголт зэрэгт тохируулан гол санааг алдагдуулахгүйгээр зохион байгуулах боломжтой.
- Бүтээлч үйл ажиллагааг зохион байгуулахдаа дээрх жишээ болгосон 3 сонголтыг сурагчдаар нээлттэй сонгох боломжийг олгох, мөн шинэ санааг дэмжиж суралцагчдад нээлттэй боломжийг бүрдүүлнэ.
- Бүтээлч үйл ажиллагаа эхлэхээр өмнө урьдчилан хэрэглэгдэхүүнээ бэлтгэсэн байх. (өмнө долоо хоногт гарын доорх материалуудаа цуглуулсан байна).
- 35 минутын дараа завсарлага заавал авна.

Сэдэв 8. Өвлийн орчин

Зорилго: Гарын доорх материал ашиглан гэр бүл, анги хамт олноороо хамтран "Өвлийн хотхон" бүтээж, байгаль орчиндоо ээлтэй амьдрах дадалд суралцах.

Суралцахуйн үр дүн: БШ (1.2а, 1.4в), ДУД (1.2б, 1.2л), НУ (1.1б), МХ (1.1в)

Хэрэглэгдэхүүн: Өндөгний хайрцаг, цаасан хайрцаг, хуванцар таглаа, соруул, хөвөн (цас), усан будаг, өнгийн цаас, цавуу, хайч.

Хэрэгжүүлэх жишиг үйл ажиллагаа	Чиглүүлэх асуулт
- Өвлийн орчны зураг/бичлэг харж, гарын доорх материал, хайрцгаар юу хийж болох талаар ажиглан ярилцана.	- Өвөл байгальд ямар өөрчлөлт гардаг вэ? - Өндөгний хайрцаг, цаасан хайрцгаар байгальд ээлтэй өвлийн хотхон барьж чадах уу?
- Багуудад хуваагдаж, хотхоны бүтэц (байшин, гацуур, зам, цас)-ийг хэн яаж хийх үүргийг хуваарилан төлөвлөнө.	- Манай хотхонд юу юу байх ёстой вэ? - Хэн ямар материалыг ашиглан байшин/гацуур хийх вэ?
- Хайрцаг ба таглааг цавуудан байшин барьж, хөвөнгөөр цасан бүрхүүл, өндөгний хайрцгаар гацуур хийн "Өвлийн орчин" 2 ба 3 хэмжээст бүтээл хийнэ.	- Хайрцгийг яаж холбовол бөх бат болох вэ? - Хөвөнгөө яаж наавал өвлийн цас шиг харагдах вэ?
- Хотхоны тогтвортой байдлыг шалган, нурж буй хэсгийг чангалан, өнгө чимэглэл нэмж баяжуулна.	-Манай хотхоны байшин, гацуур сайн тогтож байна уу? -Ямар чимэглэл нэмж баяжуулах вэ?
- "Өвлийн орчин" бүтээлээ ангийнхандаа танилцуулж, гарын доорх материалыг ашиглах ба усаа хэмнэх байгальд ээлтэй дадлыг хэвшүүлнэ.	- Гарын доорх материалыг дахин ашиглах нь байгальд ямар ач холбогдолтой вэ? - Гэртээ усыг яаж хэмнэж болох вэ?

Багшийн анхаарах зүйл:

- Гарын доорх материалыг хичээлээс долоо хоногийн өмнө суралцагчдаар бэлтгүүлсэн байна.
- 4-5 хүнтэй баг (гэртээ гэр бүлийнхэнтэйгээ хамтрах) ажиллах ажлын орон зайг бүрдүүлнэ.
- Хамтын бүтээл тул хүүхэд бүрийн тэгш оролцоог хангах ба багийн ажилд урам зориг өгнө.

Сэдэв 9. Нөхөрсөг харилцаа

Зорилго: Суралцагч анги хамт олны дунд бусадтай эвтэй байх, хүндэтгэлтэй харилцахын ач холбогдлыг ойлгож, бусдыг ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрөн, өдөр тутмын үйл ажиллагаандаа идэвхтэй оролцоход оршино.
Суралцахуйн үр дүн: Нийгмийн ухаан (1.1б, 1.1в) Эрүүл мэнд (1.6а, 1.6б) Монгол хэл (1.1б, 1.1в, 1.4б) Дүрслэх урлаг, дизайн (1.2е, 1.2л)

Хэрэглэгдэхүүн: Олон өнгийн өнгөт цаас, хайч, цавуу, өнгийн харандаа, маркер

Хэрэгжүүлэх жишиг үйл ажиллагаа	Чиглүүлэх асуулт
- Багш суралцагчдад ганц нэгээрээ салангид байгаа цаасан тууз болон тэдгээрийг холбож хийсэн цаасан хэлхээний зургийг ажиглуулна. - Суралцагч ганцаараа тоглоход ямар байдаг, ангиараа хамтдаа тоглоход ямар байдаг талаар ярилцана.	- Энэ ганц цаасан тууз болон олуулаа холбогдсон цаасан хэлхээ хоёрын хооронд ямар ялгаа байна вэ? - Ганцаараа тоглох, найзуудтайгаа хамтдаа тоглох хоёр яагаад өөр байдаг юм бэ? - Ангийн найзуудтайгаа хэрхэн харилцдаг вэ? бие биедээ яаж тусалдаг вэ?
- Суралцагч багаараа "Нөхөрлөлийн хэлхээ" хийх санаа гаргана. - Хүүхэд бүр өөрийн өнгөт цаасан тууз дээр юу зурах, ямар өнгө сонгох, юу бичих, хэрхэн хэлхээг бий болгох ажлын дарааллаа хэлэлцэн төлөвлөнө.	- Өөрийнхөө өнгөт туузаа найздаа илүү сайн ойлгуулахын тулд дээр нь юу зурж эсвэл бичвэл тохиромжтой вэ? - Бид бэлэн болсон цагаригуудаа ямар дарааллаар холбож урт хэлхээ болгох вэ? - Хайч, цавуу, өнгөт цаасаа яаж найзууддаа аюулгүй, дамжуулж хэрэглэх вэ?

- Суралцагч сонгосон өнгөт цаасан дээрээ өөрийн нэрийг бичиж, найздаа зориулж зураг эсвэл бичвэр бичнэ.  Дараа нь цаасаа дугуйлан цавуудаж цагариг болгоод, хажуугийнхаа найзын цагариг дундуур сүвлэн холбож, гурван хэмжээст урт цаасан хэлхээг бүтээнэ.	- Найзынхаа цагариг дундуур өөрийн цаасыг хэрхэн залгах вэ?" - Зурсан зураг, бичсэн нэр чинь цагаригаа дугуйлахад гадна талдаа тод харагдаж чадаж байна уу?
- Суралцагч залгасан хэлхээгээ өргөж харан, цагариг салсан эсэхийг шалгана. - Цавуу нь сайн наалдаагүй задарсан хэсэг байвал дахин нааж, зурсан зураг нь харагдахгүй байвал нэмж тодруулна.	- Бидний хийсэн хэлхээг татахад салж байна уу, эсвэл бат бөх байна уу? - Ямар нэг цагариг задарч байвал яаж засаж сайжруулах вэ? - Энэ хэлхээг улам өнгөлөг, гоё болгохын тулд хаана нь юу нэмж зурах вэ?
Ангиараа бүтээсэн урт "Нөхөрлөлийн хэлхээ"-гээ ангийнхаа самбарт байрлуулна. Хүүхэд бүр өөрийн хийсэн цагаригийг заан, найздаа зориулж юу зурснаа тайлбарлан ярьж, бие биедээ урам өгнө.	- Ангиараа хамтарч ийм урт хэлхээ хийхэд та бүхэнд ямар сэтгэгдэл төрсөн бэ? - Хамтран ажиллах явцад найздаа хэрхэн тусалсан бэ? - Цаасан хэлхээ шиг бид бие биетэйгээ дандаа нөхөрсөг байхын тулд цаашид юу анхаарах вэ?

Багшийн анхаарах зүйл:

- Суралцагчийг 4-5 хүнтэй баг болгон хуваарилна. Баг бүрийн дунд хайч, цавуу, өнгөт цаасыг дундаа хамтран ашиглахаар байрлуулна.
- Найз нөхдийн харилцаанаас нөхөрлөлийн хэлхээ бий болдог болохыг багаар ажиллахдаа, бие биетэйгээ харилцах бүрд илэрч байгааг чиглүүлэн удирдана.
- Хамтын бүтээл тул хүүхэд бүрийн тэгш оролцоог хангах ба багийн ажилд урам зориг өгнө.
- Аюулгүй ажиллагааны дүрмийг баримтлах зааварчилгааг өгнө.

Сэдэв 10. Манай сургуулийн орчны амьд байгалийн зураглал

Зорилго: Сургуулийн орчны ургамал, жижиг амьтдыг ажиглан, зураг тэмдгээр бүртгэх, тоолж харьцуулах, хамтаараа газрын зураг (байгалийн зураглал) бүтээн хэрэглэж үзэн сайжруулах замаар суралцагчийн судлан шинжлэх, асуудал шийдвэрлэх, харилцах, хамтран ажиллах чадамжийг хөгжүүлнэ.

Суралцахуйн үр дүн: БШ (1.1а), МХ (1.1б, 1.1в), Мат (1.1б)

Хэрэглэгдэхүүн: Баг бүрд нэг зураг ажиглалтын хуудас, харандаа, бичих хатуу хавтас, том цаас, өнгийн харандаа. Багшийн урьдчилан зурсан сургуулийн байр, хаалга, явган замыг харуулсан энгийн тойм зураг.

Хэрэгжүүлэх жишиг үйл ажиллагаа	Чиглүүлэх асуулт
- Сургуулийн гадна орчныг харж, ямар ургамал, амьтан харж байснаа ярилцана. - Багш А, Б талбайн хэсгийг танилцуулж, “Аль хэсэгт илүү олон мод байх бол?”, “Шувуу хаана харагдах бол?” гэж таамаглуулна.	- Манай сургуулийн хашаанд юу ургадаг вэ? - Ямар амьтан харж байсан бэ? - Бид өнөөдөр юу олж харах бол?
- Ажиглалтын хуудасны мод, цэцэг, шувуу, жижиг амьтны зургуудтай танилцана. - Хаанаас ажиглах, ямар дарааллаар явахаа тохирно. - Багийн хүүхдүүд ажиглах, тоолох, тэмдэглэх үүргийг ээлжлэн гүйцэтгэнэ.	- Бид эхлээд хаана очих вэ? - Харсан зүйлээ яаж тэмдэглэх вэ? - Амьд зүйлсийг гэмтээхгүй яаж ажиглах вэ?
- А, Б талбайн амьд биеийг тус бүр богино хугацаанд ажиглана. - Харсан мод, цэцэгтэй ургамал, шувуу, жижиг амьтнаа зураг хуудсанд зураасаар тэмдэглэнэ. - Дараа нь нэг төрлийн зүйлийг сонгон хоёр хэсгийн тоог харьцуулна.	- Энд юу харагдаж байна вэ? - Хэдэн мод байна вэ? - Аль хэсэгт мод олон байна вэ? - Харагдаагүй зүйл байна уу?

- Тойм зураг дээр ажигласан газартаа мод, цэцэг, амьтны энгийн тэмдэг зурна. - Өөр багт зургаа өгч, "Модтой хэсгийг заагаарай" гэх мэтээр хэрэглүүлж үзнэ. - Олж чадахгүй байвал зам, хаалга эсвэл тэмдгийг тодруулан нэмнэ.	- Модоо зураг дээр хаана зурах вэ? - Найзууд маань энэ газрыг олж чадах уу? - Олоход хялбар болгохын тулд юу нэмэх вэ?
- Багуудын зургийг нэгтгэн "Манай сургуулийн амьд байгалийн зураглал" бүтээнэ. - Хүүхэд бүр харсан нэг зүйлээ зааж тайлбарлана. Ургамал амьтдыг хэрхэн хамгаалах санаагаа зургаар илэрхийлнэ.	- Чи юу олж харсан бэ? - Шувууг дахин ирэхэд заавал тэр газраа байх болов уу? - Эдгээр ургамал, амьтныг хамгаалахын тулд бид юу хийж болох вэ?

Багшийн анхаарах зүйл:

- Ажиглах хоёр талбайг урьдчилан сонгож, хүүхдүүдийн явах хүрээг тодорхойлох.
- Сургуулийн хашаанаас ажиглалт хийхэд тохиромжтой, аюулгүй хоёр жижиг талбай сонгож, А, Б гэж тэмдэглэнэ. Жишээлбэл, модны дэргэдэх болон цэцгийн мандлын хажуугийн хэсэг гэх мэт.
- Суралцагчид 3–4 хүүхэдтэй багаар, багшийн хяналтад ажиглана.
- Хүүхдүүдэд зориулсан сургуулийн тойм зургийг энгийнээр бэлтгэх; газрын зургийн хэмжээ, зүг чигийг нарийн зөв зурахыг шаардахгүй байх.
- Мод, цэцэг, шувуу зэрэг 3–4 танил бүлгээр ажиглуулах. Ургамал, амьтны зүйлийн нэрийг заавал мэдэхийг шаардахгүй байх.
- Цэцгийг нэг бүрчлэн бус, цэцэгтэй ургамлыг тоолох зэрэг тоолох нэгжийг эхэнд нь ойлгуулах. Олон байвал тав хүртэл тоолоод "5-аас олон" гэж тэмдэглэж болно.
- Хөдөлж буй нэг амьтныг давтан тоолохгүй байхад туслах.
- Амьтан харагдаагүй бол "Энд амьтан байдаггүй" гэж дүгнүүлэхгүй, "Биднийг ажиглах үед харагдаагүй" гэж хэлүүлэх.
- Навч, цэцэг таслахгүй, үүр болон жижиг амьтдыг оролдохгүй, чулууг эргүүлж амьдрах орчныг нь өөрчлөхгүй байх.
- Баг бүр нэг ажиглалтын хуудас ашиглаж, хүүхэд бүрд оролцох боломж олгох.
- Газрын зургийг үзэмжээр нь харьцуулахгүй; ажиглалтаа тэмдэглэсэн байдал, бусдаар хэрэглүүлэн сайжруулсан оролдлогыг дэмжих.

Суралцагчийн ажиглалтын хуудас 1. Бид юу олж харсан бэ?

Ажиглах зүйл	А хэсэг	Б хэсэг
Мод		
Цэцэгтэй ургамал		
Шувуу		
Жижиг амьтан		

Харьцуулъя: Мод аль хэсэгт олон байсан бэ? ☐ А хэсэгт ☐ Б хэсэгт ☐ Тэнцүү

Газрын зургаа шалгая: Найзууд маань заасан газрыг олсон уу? ☐ Олсон ☐ Бид тусалсан

Сэдэв 11. Чарга угсрах

Зорилго: Суралцагчид бодит STEAM хэрэглэгдэхүүн ашиглан чарганы 3 хэмжээст загварыг дарааллын дагуу угсарч, тоглонгоо суралцах.

Суралцахуйн үр дүн : БШ(1.3а), ДУД(1.2б, 1.2м), МАТ(1.2а, 1.2б, 1.4а), МХ(1.1б, 1.1в), ЭМ(1.3а), НУ(1.1л).


Хэрэглэгдэхүүн:

- Junior Robot хэрэглэгдэхүүн- Утас - 1ш, Махир тулгуур (цэнхэр) - 2ш, 11т тулгуур - 4ш, 7т тулгуур - 2ш, Г тулгуур (цэнхэр) - 2ш, 3т тулгуур - 4ш, Урт боолт - 6ш, Дунд боолт - 10ш
- Угсралтын заавар (ном)
- Танилцуулга хичээл (ppt)
- Зураг, проектор

Хэрэгжүүлэх жишиг үйл ажиллагаа	Чиглүүлэх асуулт


- Таавар таалган хичээлийн сэдвийг тодруулж, чарганы бүтэц (суурь, хөл/судал, арал, татах олс)-ийг зураг болон бодит үзүүлэнгээр харуулна. - Чаргыг монголчууд өвлийн улиралд аргал, түлээ, ус, мөс, ачаа зөөх болон хүүхэд залуус тоглож наадахад ашиглаж ирсэн уламжлалт ахуйтай холбон тайлбарлана.	- "Уруу газар унаж давхидаг, өгсүүр газар хөтөлж чирдэг"гэж юуг хэлж байна вэ? - Дээр үед өвөө, эмээ нар цасан дээгүүр ачаагаа юугаар зөөдөг байсан бол? - Чарга яагаад цас, мөсөн дээгүүр шигдэхгүй амархан гулсдаг юм болоо? - Чаргыг хүн татах, морь/үхэр татах хоёрын ялгаа юу вэ?

- Хэрэгслээ ашиглах, аюулгүй ажиллах зааврыг танилцуулна. Чарга бүтээхэд орох хэрэглэгдэхүүнийг (тулгуур, Г тулгуур, махир тулгуур, утас, боолт) нэрлэн танилцуулна.
- Жижиг боолт, эд ангийг амандаа хийхгүй байх, шалан дээр унагаахгүй, бусдын хэрэгсэлтэй холихгүй байх аюулгүй ажиллагааны дүрмийг тохирно.
- Угсралтын зурган зааврын дагуу чарганы баруун, зүүн тал, тулгуур ба олсыг дарааллаар нь угсарна.



- Чарганы хоёр тал ижил хэмжээтэй, нүхний тоо нь таарч байна уу?
- Г тулгуур ба махир тулгуурыг аль чиглэлд харуулж холбовол зөв болох вэ?
- Чарганы хоёр тал тэнцүү биш байвал ямар хүндрэл гарах вэ?
- Татах утас ба олсыг чарганы аль хэсэгт бэхэлбэл ачаа татахад амархан бэ?

Угсарсан чарга:



- Угсарсан чаргаа налуу тавцан дээр гулсуулж турших, хөдөлгөөнийг ажиглана. - Чарга хазайх, гулсахгүй байх, боолт сулрах зэрэг алдааг сурагчид бие даан илрүүлж засна. - Чаргыг ачааны чарга, нохой чарга, сансрын чарга....гэх мэт янз бүрийн чарга болгон хашлага, суудал, чимэглэл нэмж шинэ санаагаар баяжуулна. - Сурагчид багаар болон ганцаарчлан бүтээсэн чаргаа ангийнхандаа танилцуулж, онцлог ба сайжруулсан хувилбараа тайлбарлана. - Хамгийн хурдан бөгөөд бат бөх гулссан чарганы физик шалтгааныг (тэнцвэр, үрэлт) багшийн чиглүүлгээр ярилцана. - Хичээлийн төгсгөлд китийн эд ангийг төрөл төрлөөр нь ангилан хайрцагт бүрэн хурааж хэвшинэ.	- Найзууддаа өөрийн хийсэн чарганы онцлогийг тайлбарлан үзүүлнэ үү? - Чарганы аль хэсгийг хийхэд хамгийн сонирхолтой эсвэл хэцүү байсан бэ? - Бусад багийн чарганаас суралцах эсвэл санаа авахаар зүйл юу байв? - Эд ангиудыг яагаад төрөл төрлөөр нь ангилан хураах хэрэгтэй вэ?

Багшийн анхаарах зүйл:

- Чаргыг зөвхөн тоглоом гэхээс илүү монголчуудын ахуй, өвлийн улиралд ачаа тээвэрлэх, аргал түлээ, ус зөөхөд ашиглаж ирсэн уламжлалтай холбон тайлбарлах;
- Суралцагчид жижиг эд ангиуд (боолт, утас, тулгуур гэх мэт)-ыг амандаа хийхгүй, шалан дээр унагаахгүй, өөрийн багцын эд ангийг бусдынхтай холихгүй байх аюулгүй ажиллагааны дүрэм баримталж буй эсэхэд байнгын хяналт тавих;
- Чарга хазайх, гулсахгүй байх, холболт сул байх зэрэг түгээмэл алдааг сурагчид бие даан олж засах боломжийг олгох үүднээс шууд засаж өгөхөөс илүүтэйгээр "Аль хэсгийг өөрчилбөл дээр вэ?" гэх мэт чиглүүлэх асуултуудыг түлхүү ашиглах;
- Туршилтын үеэр сурагчдын аюулгүй байдлыг хангаж, бусдын бүтээлийг хүндэтгэх, хамтран ажиллах эерэг хандлагыг төлөвшүүлэх; хичээлийн төгсгөлд эд ангиудыг төрөл төрлөөр нь ангилан хайрцагт бүрэн хураах дадлыг хэвшүүлэх.

Сэдэв 12. Монгол гэр угсрах

Зорилго: Суралцагчид бодит хэрэглэгдэхүүн ашиглан Монгол гэрийн хоёр хэмжээст загварыг дараалллын дагуу угсарч, тоглонгоо суралцах.

Суралцахуйн үр дүн : БШ(1.3а), ДУД(1.2б, 1.2м), МАТ(1.2а, 1.2б, 1.4а), МХ(1.1б, 1.1в), ЭМ(1.3а), НУ(1.1л).


Монгол гэрийн хэсэг бүрийг китийн тулгууртай харьцуулж, нүхний тоог тоолох, тулгуурын чиглэлийг тааруулах замаар угсралтын алдааг бие даан илрүүлж засах чадварыг хөгжүүлнэ.

Хэрэглэгдэхүүн:

- Junior Robot хэрэглэгдэхүүн- Дөрвөлжин тулгуур - 1ш, Махир тулгуур (цагаан) - 2ш, 11т тулгуур - 3ш, 7т тулгуур - 6ш, 5т тулгуур 1ш, 3т нимгэн тулгуур - 1ш, 3 боолт - 1ш, Дунд боолт - 17ш, 1.5 боолт - 2ш
- Угсралтын заавар (ном)
- Танилцуулга хичээл (ppt)
- Зурагт, проектор


Хэрэгжүүлэх жишиг үйл ажиллагаа	Чиглүүлэх асуулт
- "Цасан цагаан биетэй, цаг улирлаар нүүдэг..." тааврaар сэдэлжүүлж, монгол гэрийн зураг, слайд үзүүлнэ. - Монгол гэр нь нүүдэлчин түмний уламжлалт сууц, өвөлдөө дулаан, зундаа сэрүүн, амархан буулгаж нүүлгэдэг онцлогийг ярилцана. - Гэрийн үндсэн бүтэц (тооно, унь, хана, багана, хаалга, эсгий бүрээс) болон гэрт баримтлах дэг ёс, цээрлэх зүйлийг танилцуулна.	- Тааварт гарсан "Цасан цагаан биетэй, бүсээ хүнээр бүслүүлдэг" гэдэг нь юуг хэлж байна вэ? - Та нар Монгол гэрт орж үзэж байсан уу? Ороход ямар санагддаг вэ? - Монгол гэр яагаад дөрвөлжин биш, дугуй хэлбэртэй байдаг юм болоо? - Гэрийн хамгийн дээд талын дугуй цонх шиг зүйлийг юу гэж нэрлэдэг вэ? Хэрэв багана нь байхгүй бол гэр яах вэ?

- Junior Robot китийн тулгууруудыг (дөрвөлжин, махир, 11т, 7т, 5т, 3т тулгуур, боолт) үзүүлж, гэрийн ямар хэсгийг орлуулахыг тайлбарлана.
- Боолт, тулгуурыг амандаа хийхгүй байх, ширээний голд байрлуулан бусдынхтай холихгүй байх аюулгүй ажиллагааг сануулна.
- Зурган зааврын дагуу тооно, унь, хана, багана, хаалгыг китийн тулгуураар төлөөлүүлэн 2 хэмжээст загвар болгон угсарна.
- Хэрэгслээ ашиглах, аюулгүй ажиллах зааврыг танилцуулна. Тархи, мотор, тулгуур, гол, боолт, араа, холбогчийн нэршлийг танилцуулна.



- Дөрвөлжин ба махир тулгуур нь Монгол гэрийн ямар хэсгийг (хаалга, хана, тооно) илтгэж байна вэ?
- Унь болон баганыг ямар тулгуураар төлөөлүүлэн холбож байна вэ?
- Тулгуур дээрх нүхний тоо зөв таарч байна уу?
- Хоёр тулгуурыг бат бөх холбохын тулд ямар боолт сонгох вэ?

Угсарсан Монгол гэр:



- Угсарсан гэрийн загварын холболт бүрийг шалгаж, сул байгаа боолтыг чангалан бат бөх байдлыг хангуулна. - Тулгуур зөрөх, хазайх үед заавар болон нүхний тоог дахин тулгаж, сурагчдаар бие даан алдааг нь илрүүлж засуулна. - Угсарсан гэрээ чимэглэж, "Сансарт байдаг гэр", "Нисдэг гэр", "Бяцхан амьтны гэр" гэх мэт бүтээлч шинэ санаагаар баяжуулна. - Сурагчид баг эсвэл салаа бүрээс гарч, угсарсан Монгол гэрийнхээ эд ангиудыг нэрлэн, өөрчилж чимэглэсэн шинэ санаагаа танилцуулна. - Загвартайгаа холбогдуулан монгол гэрт зочлох, босгон дээр гишгэхгүй байх, хүндэтгэлтэй мэндлэх дэг ёсыг ярилцаж эргэцүүлнэ. - Гэрийн загварыг гэмтээлгүй салгаж, китийн эд ангийг төрөл төрлөөр нь хайрцагт бүрэн хураан цэгцэлнэ.	- Чиний угсарсан гэрийн холболт сул эсвэл хазайсан байна уу, аль боолтыг чангалах вэ? - Гэрийн аль хэсгийг хийхэд хамгийн их анхаарал шаардсан бэ? - Гэрийн загвараа илүү сонирхолтой болгохын тулд юу нэмж чимэглэж болох вэ? - Үүлэн дээр эсвэл сансарт байдаг гэр хийвэл ямар хэлбэртэй болох бол? - Найзууддаа өөрийн угсарсан гэрийн онцлог ба эд ангиудыг заан тайлбарлана уу? - Найзын чинь хийсэн гэр чинийхээс юугаараа ялгаатай, сонирхолтой байна вэ? - Монгол гэрт зочлохдоо хүүхдүүд бид ямар дэг ёс сахих ёстой вэ? - Эд ангиудыг салгаж хайрцаглахдаа яагаад дутуу арилгаж болохгүй вэ?

Багшийн анхаарах зүйл:

- Монгол гэрийн хэсгүүдийн (тооно, унь, хана, багана, хаалга) нэр цээжлүүлэхээс илүү хэсэг бүрийн үүрэг, онцлогтой холбон ойлгуулах; “Гэрт орж үзсэн үү?”, “Яагаад дугуй хэлбэртэй байдаг вэ?” гэх мэт асуултаар хүүхдийн өөрийн туршлагаас хичээлийг эхлүүлэх;
- Суралцагчид жижиг эд ангиуд (боолт, тулгуур, холбогч гэх мэт)-ыг амандаа хийхгүй, шалан дээр унагаахгүй, китийн эд ангийг ширээний голд байрлуулж, бусдын эд ангитай холихгүй байх аюулгүй ажиллагааны дүрэм баримталж буй эсэхэд байнгын хяналт тавих;
- Гэрийн аль хэсгийг ямар тулгуур орлуулж болохыг багш шууд заахгүй, угсралтын явцад гацсан үед “Энэ аль хэсэгтэй холбогдох вэ?”, “Нүхний тоо таарч байна уу?” гэх мэт чиглүүлэх асуултуудыг түлхүү ашиглаж, зурган зааврын дарааллыг алгасахгүй мөрдүүлэх;
- Суралцагч бүр идэвхтэй оролцох нөхцөлийг бүрдүүлж, бүтээлч санааг дэмжих, бусдын бүтээлийг хүндэтгэх хандлагыг төлөвшүүлэх;
- Хичээлийн төгсгөлд гэрийн загварыг гэмтээлгүй салгаж, эд ангийг ангилан хайрцагт бүрэн хураах дадлыг хэвшүүлэх.

ЭХ СУРВАЛЖ

1. БЯ.(2026). Бага боловсролын сургалтын хөтөлбөр.УБ.
2. БШУЯ.(2022).Хичээлээс гадуурх сургалтын ажлын үлгэрчилсэн хөтөлбөр, хэрэгжүүлэх зөвлөмж.(сайжруулсан хувилбар)
3. БЯ.(2025). Үр дүнд суурилсан сургалтын хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэхэд баримтлах арга зүйн удирдамж.
4. БСҮХ.(2023). Монгол хүүхдийн бие бялдар, нийгэмшил, танин мэдэхүйн хөгжлийн онцлог. УБ
5. OECD.(2019a).*OECD Learning Compass 2030: Concept Note on Creativity.* OECD Future of Education and Skills 2030.
   (https://www.oecd.org/content/dam/oecd/en/topics/policy-issues/future-of-education-and-skills/learning-compass-constructs/Creativity.pdf)
6. OECD.(2019b). *Fostering Students' Creativity and Critical Thinking:What it Means in School.OECD Publishing.*
7. OECD.(2023).PISA 2022 Assessment and Analytical Framework.OECD Publishing.(https://www.oecd.org/en/publications/pisa-2022-assessment-and-analytical-framework_dfe0bf9c-en/full-report/component-5.html)
8. Craft, A. (2005). Creativity in Schools: Tensions and Dilemmas. Routledge.
9. Guilford, J. P. (1950). Creativity. American Psychologist, 5(9), 444–454.
10. Lucas, B., Claxton, G., & Spencer, E. (2013). Progression in Student Creativity: Diagnosing a New Assessment Framework. OECD Education Working Papers, No. 86, OECD Publishing.
11. Runco, M. A., & Jaeger, G. J. (2012). The Standard Definition of Creativity. Creativity Research Journal, 24(1), 92